

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-25
<hr/>	
<i>1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	4-5
<i>2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	5-25

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 10 дугаар сарын 02-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 24 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Батлут, Б.Батцэцэг, Ж.Баясгалан, П.Мөнхтулга;

Томилоттой: Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Булгантуяа.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, мөн албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Горимын санал дэмжигдсэн тул дээрх батлах санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Н.Ууганбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, мөн албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Төслийн талаарх танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан, Д.Батбаяр, Х.Болормаа, Д.Пүрэвдаваа, Ж.Ганбаатар, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Д.Батбаяр, Д.Пүрэвдаваа, П.Ганзориг, Г.Дамдинням, Б.Мөнхсоёл, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Ц.Даваасүрэн: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 40 минут үргэлжилж, 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 04 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их Засаг” танхим,
15 цаг 24 минут

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Даваасүрэн: Төсвийн байнгын хорооныхоо гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Та бүхэн тойрогтоо ажиллаад, амраад эрч хүчтэй ирсэн байх. Намрын чуулганы үйл ажиллагаанд амжилт хүсье. Манай Байнгын хорооны гол ажил бол эхэлж байна. 2025 оны төсөв хэлэлцэж, батлах ажил байгаа. Тэгээд өнөөдрийн хуралдаанаас бид энэ ажилдаа шуурхайлан орох нь.

Өнөөдрийн хуралдааны ирц 56 хувь буюу 25 хүнээс 14 ирсэн байна. Би ирсэн гишүүдийг танилцуулъя. Миний бие, Норовын Алтанхуяг, Аубакир, Далайн Батбаяр, Рэнцэндоржийн Батболд ирсэн. Жигжидийн Батжаргал орон нутаг орон нутаг томилоттой гэж байгаа юм байна. Дамбын Батлут чөлөөтэй, Хөххүүгийн Болормаа ирсэн. Жамбалын Ганбаатар ирсэн. Гомбын Ганбаатар ирсэн. Пүрэвжавын Ганзориг ирсэн. Хассуурийн Ганхуяг ирсэн. Гонгорын Дамдинням ирсэн. Баатаржавын Мөнхсоёл ирсэн. Загджавын Мэндсайхан ирсэн. Банзрагчийн Түвшин ирсэн. Баттогтохын Чойжилсүрэн ирсэн байна. Хуралдааны ирц хангалттай байгаа учраас өнөөдрийн 2024 оны 10 сарын 2-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хороогоор хэлэлцэх асуудлыг би та бүхэнд танилцуулъя. 2 асуудал байгаа.

Эхний асуудал.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах асуудал байгаа.

Төсвийн байнгын хорооны тогтоолын төсөл та бүхэнд тараагдсан.

2 дахь асуудал Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байгаа. Бид хэлэлцэх эсэхийг иийдээд санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд танилцуулна. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу. Энэ 2 асуудалтай холбогдуулаад. Алга байна. Алга байгаа учраас эхнийхээ асуудалд орё.

Төсвийн байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Тогтоолын төсөл байна уу. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт ээлжит чуулганы хэлэлцэх асуудлыг баталсан Улсын Их Хурлын тогтоолд заасан хууль тогтоомжийн төслийн хэлэлцэх дарааллыг зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын даргаас сар бүр захирамжаар батална гэж, мөн зүйлийн 5.6 дахь хэсэгт энэ хуулийн 10.5-д заасан дарааллыг үндэслэн хэлэлцэх асуудлын цаглаварыг Байнгын хороод баталж мөрдүүлнэ гэж заасны дагуу энэ цаглаварыг баталсан байгаа. Тэгээд та бүхэнд тараасан байгаа. Цаглавартай холбогдуулаад, тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу. Алга уу. Алга байна. 2, 3 асуудал тодорхой байгаа учраас та бүхэн. Гишүүд асууж, үг хэлж дууссан. Санал хураалт явуулна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглаварыг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт

явуулъя. Батбаяр гишүүнийх эсрэг гарчихсан байна. Та дэмжсэн үү. Дэмжээгүй юм уу. Сая хэнийх эсрэг гарчхав. Харин нэгнийх нь гарчихлаа. Хэнийх гарчхав. Тэр хүн л уг нь санал гаргамаар байх юм. Үгүй ээ, үгүй. Батбаяр гишүүний микрофоныг өгье.

Д.Батбаяр: Миний энэ төхөөрөмж ...

Ц.Даваасүрэн: Батбаяр гишүүн санал гаргая.

Д.Батбаяр: Би уг нь ирцдээ орчихсон байсан. Тэгсэн миний энэ тоног төхөөрөмж ажилласангүй л дээ. Тийм учраас дахиж санал хурааж өгнө үү гэж хүсье.

Ц.Даваасүрэн: Батбаяр гишүүний гаргасан горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Техникийн гэмтэл гарсан учраас хүчингүй болгоё. Санал хураалтыг дахин явуулна. Техникийнхэн дахиад шалгачихъя. Энэ тест шүү. Зөвшөөрснөө л дарчих. Болохгүй байна даа. Их анхааралтай л яахгүй бол болохгүй байна. Хэнийх дээр буруу гарчхаад байна. Болормаа чи дахиад. Яг жинхэнэ санал хураалт явуулна шүү. Батбаяр гишүүний гаргасан горимын саналын дагуу санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллоор дахин санал хураалт явуулъя. Зөвшөөрсөн 9.56,3 хувиар дэмжигдсэн байна.

Тэгвэл тогтоолын төслийг батлахыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. 9 гишүүн дэмжиж 56,3 хувиар тогтоолын төсөл батлагдсан байна. Санал хураалт явуулж дууслаа. 1 дэх асуудлыг хэлэлцэж дууслаа. Тогтоол ингээд шууд батлагдсанд тооцогдоод явчихаар байгаа юу. Ингээд тогтоолын төсөл батлагдлаа.

15.31 цаг.

2 дахь асуудалдаа орё.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулъя. Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай. Лувсаньямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Намжилдоржийн Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Зандангийн Баярхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого зохицуулалтын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга. Жавхлан сайд яагаад энд байхгүй байгаа юм. Жавхлан сайдыг оруулна шүү. Жавхлан сайдыг оруулъя. Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны өрийн удирдлагын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүү, хөгжлийн удирдлагын хэлтсийн дарга Батбаатарын Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга гэсэн ийм хүмүүс оролцох

ёстой. Энэ хүмүүсийг оролцуулъя. Тогтвортой байдлын зөвлөлийн 2 ирсэн байна. Бусад нь алга байна. Оруулъя. Хуралдаанд хариулт өгөх ёстой. Оруулж ирж байгаа төсвийн хүрээний мэдэгдлээ хамгаалах ёстой. Танилцуулгыг нь Сангийн сайд хийнэ биз дээ. Гантөмөр хийх юм байна. Энэ чинь төсвийн хүрээний мэдэгдэл шүү дээ нээрээ. Гантөмөр сайдыг дуудъя. Угаасаа орж ирж нөгөө танилцуулга хийхээс өөр арга байхгүй. Жавхлан сайд танилцуулчихъя. 3 номерын микрофон. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Жавхлан танилцуулна. Жавхлан сайдын микрофон. 3 номерын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Эрхэм Төсвийн байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2024 оны орсон өөрчлөлтөөр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгадаг үзүүлэлтүүдээс нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ, нэгдсэн төсвийн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ гэсэн 2 үзүүлэлт хасагдаж, тэдгээрийн оронд нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ, нэгдсэн төсвийн суурь тэнцэл гэсэн 2 үзүүлэлт нэмэгдсэн. Хуулийн уг өөрчлөлттэй уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох тооцоолол үндэслэлийг та бүхэнд танилцуулж байна.

Манай улсын эдийн засгийн өсөлт цар тахлын үед -4,6 хувь болж буурч байсан бол сүүлийн 2 жилд 5 болон 5-7,4 хувиар тус тус өсөөд байна. Цаашид Оюутолгойн уул уурхайн олборлолтын хэсэгт зэс, алтны агууламж нэмэгдэх, ашигт малтмалын экспортын үйл ажиллагаа жигдэрсэн, аялал жуулчлал,

үйлчилгээний салбарын үйл ажиллагаа сэргэсэн ба мега төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэхтэй холбоотойгоор эдийн засгийн өсөлт эрчимжиж, 2025 онд 8 хувьд 2026, 2027 онд тус тус 6,5 хувьд орчимд тогтвортой хадгалагдахаар байна.

Мөн цар тахал болон Украйнд болж буй дайны нөлөөгөөр 2022 онд 16,9 хувь болж өсөөд байсан инфляц 2023 оны эцэст 7,9 хувь болж буурсан. Цаашид валютын нөөцийг нэмэгдүүлж, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой нэмэгдүүлэн төсөв мөнгөний оновчтой бодлогыг хэрэгжүүлснээр 2025 онд 7,5 хувь, 2026 онд 5 хувь, 2027 онд 4 хувьд хүргэхээр хуулийн төсөлд тусгагдлаа.

Тус хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан нэгдсэн төсвийн орлого, зарлага, тэнцвэржүүлсэн болон суурь тэнцэл Засгийн газрын өртэй холбоотой төсвийн тусгай шаардлагуудыг нэгэн зэрэг хангасан болно. Анхаарал тавьсанд баярлалаа. Хэлэлцэн баталж өгнө үү.

Ц.Даваасүрэн: Жавхлан сайдад баярлалаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар танилцуулгатай холбогдуулаад асуух асуулттай гишүүд байна уу. Байвал нэрээ өгье. Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Мэндсайхан гишүүн асуултаа асууя.

З.Мэндсайхан: Монгол Улсын төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл төсвийн төсөөллийн талаар танилцуулгыг сонслоо. Тэгээд энэ дээр ирэх жил дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь хэмжээг 8 хувь гэж тооцсон байна л даа. Тэгээд инфляцаа 7,5 гээд тооцчихсон. Энэ 8 хувь гэдэг ямар үндэслэл дээр гарч ирсэн юм

бэ. Засгийн газар одоо 14 том төсөл хэрэгжүүлнэ. Мега төслөө хэрэгжүүлье гэж байна. Энийг дагаад мэдээж импортыг дэмжсэн ийм бодлого л явагдана. Энийг чинь дагаад хэрэглээний үнэ өснө. Тэгэхээр энэ дээрээ ямар тооцооллоор энэ тоонуудыг гаргаж ирэв гэдгийг тодруулж өгөөч.

Ц.Даваасүрэн: Жавхлан сайд хариулах уу. Хэн хариулах вэ. Эдийн засаг, хөгжлийн яамнаас хүн байна уу. 2 номерын микрофоныг өгье. Нэрээ хэлээд тэгээд асуултад хариулаарай.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яам, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя.

Эдийн засгийн өсөлт 2023 оны эцсийн байдлаар 7,4 хувиар өссөн байгаа бодитоороо. Бид 7 хувиар өсөх болов уу гэсэн таамаглалтай байсан. Бидний төсөөллөөс, таамаглалаас давж өссөн байгаа. 2025 оны хувьд бол 8 хувиар өснө гэж байгаа юм. Энд оруулж байгаа гол хувь нэмэр бол Оюутолгойн баяжмал дахь алт, зэсийн агууламж нэлээд нэмэгдэж байгаа. Энэ жилийн тухайд бол зэсийн агууламж 22, 23 хувьтай байгаа бол дараа жил зэсийн агууламж 31 хувьтай болно. Алтны агууламж 7 хувьтай бол 14 хувьтай болно. Зөвхөн энэ 2 агууламжийн нөлөөгөөр эдийн засгийн өсөлт бүтэн 1 нэгж хувиар дээшээ өсөж байгаа гэдгийг хэлье. Тэгээд бусад хүчин зүйл бол мега төслүүдийн хэрэгжилттэй холбоотой хөрөнгө оруулалтууд нэмэгдэх юмнууд байгаа. Энэ мэдээж импорт дээр бол бага зэрэг дарамттай байгаа. Гэхдээ экспорт дажгүй байх төлөвтэй байгаа учраас дараа жилдээ эдийн засгийн өсөлт хангагдчихна гэж үзэж байгаа.

Өсөлт өндөр байхад гол нөлөөлж байгаа гол юм нь нүүрсний экспорт байна. Энэ жилийн тухайд бол бид 78 сая тонн нүүрс экспортолчих болов уу гэсэн төсөөлөлтэй явж байна. Өнөөдрийн байдлаар 62 сая тонн нүүрс экспортод

гарчихсан байна. Өнгөрсөн оны эцэст бол 69 байсан. Дараа жилдээ 83 сая тонн нүүрс экспортолно гэсэн төсөөлөлтэй байгаа юм. Тэгээд энэ 83 сая тонн нүүрс бол ихэнх нь яг нь уул уурхайн компаниуд Хятад талтай гэрээгээр баталгаажуулчихсан ийм дүн байгаа учраас ер нь хангалттай гарчих болов уу гэсэн тийм тооцоололтой байгаа. Гол нөлөөллүүд ийм байна.

Ц.Даваасүрэн: Тодруулах уу. Мэндсайхан гишүүн тодруулъя.

З.Мэндсайхан: Оюутолгойн алт, зэсийг тооцоолдог болоод ирэхээр эдийн засаг ингээд дангаараа өсөөд 8 хувийн өсөлттэй гарчихна гээд хэтэрхий л өөдрөг л ярьж байна л даа. Тэгээд гол экспортын чинь нүүрс дээр ийм том тоо тавьчихаад, гэрээгээр баталгаажсан гэж байна. Үнийн хувьд энэ яг.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 2 номерын микрофон. Оюутолгой чинь тэгээд 1 талаараа ингээд экспорт дээр бичигдээд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт дээр харагдаад байгаа юм шиг мөртөө яг орж ирж байгаа нь бодит байдлаар 5 хувь шүү дээ. Тэгээд энийг бид нар нэлээн анхааралтай хандаж байхгүй бол ингээд л өсөлт байгаад байдаг. Нөгөө гарч байгаа 2 тэрбум доллар чинь хэдий хэр нь дотоодын нийт бүтээгдэхүүнд тооцогдчихдог. Экспортод тооцогдчихдог. Гэхдээ бодитой орж ирж байгаа нь 200 сая доллар л байгаа байхгүй юу. 200 сая доллар ч хүрэхгүй л байгаа байхгүй юу. Тэгээд энийг бас нэг жсоохон анхаарч байхгүй бол хий том өсөлт харагдаад байдаг. Ард түмэнд наалдах юм байхгүй байгаа байхгүй юу. Хариулъя. 2 номерын микрофон өгье.

Л.Энх-Амгалан: Үнийн хувьд асуулаа. Энэ жилийн тухай төсөвт бид нар нүүрсний үнийг 115 сая доллароор тооцсон байгаа. Экспортын үнийг. Одоо оны эхнээс дундаж нь 114 сая доллартой байна. Их ойролцоо байгаа. Одоо нүүрсний үнэ нэлээд уначихсан байна оны

эхнээсээ. Гэхдээ үүнээс цаашаа ерөнхийдөө нүүрсний үнэ буцаад сэргэнэ гэсэн хүлээлттэй байгаа. Оны төсөл болтол. Тэгэхээр 2024 оны тухайд бол үнэ дээр бол бидний тооцоолсны орчимд байхаар байна. 2025 оны хувьд бол нүүрсний үнийг 105 доллар гэж авсан байгаа. Нэлээд бууруулж авсан. Гэхдээ...

Ц.Даваасүрэн: 129 биш юм уу. 129 гэсэн байна лээ шүү дээ.

Л.Энх-Амгалан: Төсөв дээр 2 үнэ байгаа.

Ц.Даваасүрэн: Жавхлан сайд. Төсөв дээр 129 байна лээ шүү. 3 номерын микрофон.

Б.Жавхлан: Асуулт дээр би нэмж хариулъя. Зах зээлийн үнэ, тэнцвэржүүлсэн үнэ гэдэг 2 үнийн ойлголт байдаг. Төсөв хийхэд. Зах зээлийн үнэ нь нийт орлогоо тооцдог суурь үнэ. Тэнцвэржүүлсэн үнэ нь бол 129 доллар, зах зээлийн үнэ 105. Тэгээд бид аль багаар нь авдаг. Ингээд 105 доллароор авчихсан байгаа. Энэ чинь нөгөө жигнэсэн дундаж үнэ нь байхгүй юу. 129 доллар буюу энэ тэнцвэржүүлсэн үнэ бол нэлээн өндөр гарч ирж байгаа. Тэгэхдээ бид чинь бараг 20 хэдэн төрлийн нүүрс байгаа. Эндээс хамгийн өндөр коксжсон 3 нүүрс 129 доллароос давахаар ийм прогнозтой байгаа. Тэр давсан хэсэг нь орох орлого нь нөгөө тогтворжуулалтын сандаа ороод, 105 доллар маань яг үндсэн татварын тэнцвэржүүлсэн орлогыг бүрдүүлэх ханиш нь өөрөө энэ багаар нь авсан байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл 105, 129 долларын хооронд нүүрсний үнэ байхад бид бага 105.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 3 номерын микрофоныг дахиад өгчихье. Болчихсон уу. Батбаяр гишүүн асуултаа асууя.

Д.Батбаяр: Энэ өдрийн мэндийг хүргэе. Сая Мэндсайхан гишүүн эхнээс нь ер нь ерөнхийд нь асуучихлаа. Тэгэхдээ би

ахиад нарийвчлан асуучихъя. Яг энэ Тогтвортой байдлын зөвлөлийн оруулж ирж байгаа тоо болон Сангийн яамнаас оруулж ирж байгаа тоо энэ тэр нь бас зөрүүтэй байгаад байна. Түүрүүн сая 6.7, 8 гэж орж ирж байна. Хэрэглээний үнийн индекс энэ тэр дээр бас өөрчлөлттэй 8, 7.5 гээд. Энэ тоонууд маань зөрүүтэй байгаа дээр ямархуу байр суурьтай вэ гэдэг 1 дүгээр асуулт байна.

2 дугаарт нь бас энэ Тогтвортой байдлын зөвлөлөөс бас асуучихмаар байна. Та бүхэн бас яг энэ тайлангаа хүргүүлчихсэн. Гэхдээ яг байр сууриа бас яг Байнгын хорооны танхим дээр бас яг илэрхийлчихгүй юу.

Ц.Даваасүрэн: Гишүүний асуултад хариулъя. Эхлээд 3 номерын микрофон Жавхлан сайд.

Б.Жавхлан: Батбаяр гишүүн ээ, энэ тоонууд Сангийн яамнаас оруулж ирдэг тоонууд биш шүү. Өнөөдөр энд оруулж ирж байгаа бүх тоонууд Эдийн засаг, хөгжлийн яамнаас оруулж ирдэг тоо. Эдийн засаг, хөгжлийн яамнаас оруулж ирсэн энэ төсвийн хүрээний мэдэгдэл, дараагийн 2 жилийн төсөөллийн хүрээнд бид нар суурь макро тоонуудаа авч, 2025 оныхоо төсвийг тооцуулж орж ирдэг гэсэн үг. Тийм. Тэгэхээр үнийн өсөлт, инфляц, энэ бусад бүх хязгаарууд дээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас мэдээлэл өгсөн нь зөв байх.

Ц.Даваасүрэн: Тийм үү. 2 номер. 2 номерын микрофон өгье. Чи чинь ямар албан тушаалтай билээ.

Л.Энх-Амгалан: Би Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Зөвлөлөөс ирүүлсэн тоотой нэлээн зөрүүтэй байгаа. Зөвлөлөөс бол хавар 4 сард бидэнд анх төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахад тайлан ирүүлсэн. 2 төсөөлөл ирүүлсэн. Төсөөллийн дээд хязгаар, доод хязгаар

гээд. Тэгээд зөвлөлөөс ирүүлсэн тоотой яагаад зөрөөд байгаа вэ гэхээр яг нэг үндсэн ассампшнууд л зөрөөд байгаа юм. Одоо жишээ нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 25 онд нүүрсний экспортыг 50 хэдэн сая тонн, 60 хэдэн сая тонн байхаар аваад байгаа бол гэтэл одоогийн гүйцэтгэл маань манайх 60 сая тонн хүрчхээд байхад 2025 оныхоо бууруулж авч болохгүй дээр тулчхаад, тэгээд л зах зээл дээр ямар зарагдахаар байна тэр хэмжээгээр нь л бид аваад тооцохоор л шал өөр тоонууд болчхоод байгаа. Гэхдээ зөвлөлийн тооноос их ялгаатай юу гэвэл бас тийм биш. Жишээ нь нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүнийг зөвлөл 80 их наядаас 101 их наядын хооронд гэж өгсөн. Гэтэл манай тооцоо бол 95 их наяд байгаа. Зөвлөл 101 их наяд хүртэл нэмэгдүүлж болно гэснийг бид нар бага зэрэг доор авсан байгаа.

Ц.Даваасүрэн: Загварчлал нь та нар юу ашигладаг юм.

Л.Энх-Амгалан: Аргачлал дээр бол олон янзын л аргачлал байна. Салбар салбарт нь тохирсон жижиг загварууд байна. Шууд компаниудтай уулзаж мэдээлэл авч байна. Тэд нарыгаа...

Ц.Даваасүрэн: Үгүй ээ, үгүй. Ер нь ингээд нөгөө нэг загварчлалууд байдаг байсан шүү дээ. Ревайс, минимум, стандарт модуль энэ тэр гээд ямар нэг тийм загварчлал ашиглаж байгаа юм. Ер нь байгаа юу. Байгаа. Ер нь ихэнх юмнууд нь загварын яг үндсэн шугамаас л гарч ирнэ. Тэр дээр мэдээж тухайн хүнд та хоёрынх хоёулаа ижилхэн үү. Өөр загвараар хийгээд байна уу. Энхбаяр хариулъя. 6 номерын микрофон.

Н.Энхбаяр: Сайн байцаана уу. Эрхэм Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу өнгөрсөн 3 дугаар сард төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро

эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөл гэсэн ийм бичиг баримтыг боловсруулаад, Төсвийн байнгын хороо, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд хүргүүлсэн байгаа. Ингээд өнгөрсөн онд орсон Төсвийн тухай хуулийн өөрчлөлтийн дагуу Нөгөө макро эдийн засгийн анхдагч төсөөллийг манай зөвлөл хийдэг болсон анх удаа. Тэгэхээр анх удаа бид бол энэ төсөөллөө хийсэн. Загварын хувьд бол ОУВС-ийн зөвлөмж болгодог дигнар гэсэн ийм загвар дээр тулгуурлаж хийсэн байгаа. Манай энэ загвар дээр ажилладаг докторууд, бас гэрээгээр МУИС-ийн судлаач, докторууд хамтран ажилласан байгаа. Бидний хавар өгсөн тооцоолоор бол дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн боломжтой дээд хувилбар бол 6,7 хувь байх юм байна гэсэн ийм төсөөлөл өгсөн. 2025 онд. Мөн доод хязгаарыг өгсөн. Энэ хооронд байхад макро эдийн засгийн бусад үзүүлэлтүүд мөнгөний бодлого бусад үзүүлэлт нь бол сөрөг нөлөөгүй нийцтэй байна гэсэн ийм төсөөлөл өгсөн. Энэ дээр энэ үнийн холбогдолтой төсөөллүүд дээр сая бас яригдсан учраас мэдээж загварын хувьд ийм жоохон өөр өөр тохиргоонууд.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 6 номерын микрофоныг дахиад өгчихье.

Н.Энхбаяр: Үнийн тухайд би зүгээр нэг зүйлийг хэлэхийг хүсэж байна. Гаалийн статистик мэдээ болон Сангийн яамны тоон мэдээлэл дээрээс тулгуурлаад өнгөрсөн жилүүдийн нүүрсний дундаж үнэ бол 2019 онд 83 ам.доллар, 2020 онд 74, 2021 онд 170, 2022 онд 204.99, 2023 онд 125.89 гэсэн ийм үнэтэй байсан байна. Нүүрсний үнэ нэг тонн дундаж үнэ. Тэгэхээр энэ үнэ маань бол бас тодорхой хэмжээгээр буурах хандлага байна. Нөгөө талаар бид гол төлөв нөгөө эрэлт нийлүүлэлтийн талаас нь судалгаа манайд түлхүү хийгдэж байна. Нүүрсээ нийлүүлэх бололцоотой гэдэг талаас нь. Эрэлт талаас нь бид бас судлах ёстой. Энэ талаас бас манай зөвлөл болон хуучин

нөгөө Стратеги судалгааны хүрээлэн ч гэсэн энэ чиглэлийн судалгаа хийж байсан. Хятадын гол хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээ ямар байх вэ. Ялангуяа энэ дотроо олон төрлийн нүүрсний хэрэгцээ ямар байх вэ гэдэг талаас нь бас тулгаж шалгах ёстой. Тэгэхээр энэ талаасаа бид нар бас жоохон болгоомжтой хандаж байгаа юм.

Ц.Даваасүрэн: Энэтхэгийг ер нь та нар оруулж байна уу. Энэтхэг чинь нэлээн бас гангийн үйлдвэрлэл гээд нүүрсний хэрэглээ бас нэлээн өндөр болчихоод байгаа юм байна лээ шүү дээ.

Н.Энхбаяр: Харахандаа манай худалдан авагч одоогоор бол зөвхөн Хятадын Өвөр Монгол муж голдуу байгаа. Нөгөө талаар ирэх онд манай 2 хөршийн эдийн засгаа бид нар бас анхааралдаа авч үзэх ёстой. Хятадын эдийн засгийн өсөлтийг ОУВС гол төлөв 4,5-4,8 хооронд гэж төсөөлж байгаа. ОХУ-ын өчигдөр ирэх 3 жилийн төсөв өргөн барьсан. Энэ төсөл дээр ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2,5 байгаа. Тэгэхээр айхтар их нөгөө гангийн хэрэглээ өснө гэсэн төсөөлөл бид нарын хувьд бол одоогоор нэг их харагдахгүй байгаа. Металлургийн нүүрсний.

Ц.Даваасүрэн: Гол өсөлт Энэтхэгийн бүтээн байгуулалт, Энэтхэгтэй холбогдолтой бас бий болж байгаа байх. Болчихсон уу Батбаяр гишүүн ээ. Болормаа гишүүн асуултаа асууя.

Х.Болормаа: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Миний асуусан асуулт маань саяын өмнөх 2 Байнгын хорооны гишүүний асуулттай яг давхцаж байгаа учраас би саналаа татаад, хариултаа авчихсан гэж ойлгож болно.

Ц.Даваасүрэн: Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя. Алга байна.

Д.Пүрэвдаваа: Энэ өдрийн мэндийг хүргэе. Хэд хэдэн асуулт байна. Түрүүний

асуулттай давхцаж байна. 129 ам.доллаар төсөөлөөд, тэгээд өмнөх оны төсөл энэ 115-аар авна гэдэг оны төслийн нүүрсний үнэ нь 115 доллар байхаар уг нь ингээд тусгасан байх юм. Энд нэг ийм зөрөө байгаад байна. Ялангуяа Дэлхийн банкны энэ харж байгаагаар 2025 онд 12 хувиар нүүрсний үнэ буурна гэж ер нь дүгнээд байгаа юм байна. Манайх болохоор 129 байна гэсэн ийм зүйл илэрхийлээд байгаа учраас үүний зөрүүг тайлбарлаж өгөөч ээ.

2 дугаарт ОУВС-ийн тайланг харахаар 2025 онд эдийн засгийн өсөлтийг 3.3, Дэлхийн банкны тайлан дээр болохоор 2025 онд 6.6 байхаар төсөөлсөн байгаа юм. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг. Тэгээд Сангийн яам, Эдийн засгийн яам болохоор 8 байна гэдэг дээр байр суурьтай байгаа. Үүнийхээ зөрүү эсвэл энэ Дэлхийн банктэй хэр нийцэж байгаа юм. Энийгээ нэг тайлбарлаж өгөөч гэж хүсэх байна.

Дараагийн дугаарт Монгол Улсын нийт энэ кластер, кластерт ажиллаж байгаа ажиллах хүчний бууралт нь маш өндрөөр Монгол банкны тайланд тусгагдсан байгаа юм. Жишээгээр 2023 онд 35.8 мянган хүн нэрлэсэн тоогоор ажлын насны хүмүүс маань тоо нь буурсан байна. Энэ үзүүлэлт мөн өсөх хандлагатай байна гэдэг ийм Монгол банкны тайлан, дүгнэлт гарчхаад байгаа юм. Тэгэхээр эдийн засаг чинь өсөх бололцоо маш маруухан харагдаж байна гэж хэлэх гээд байгаа юм.

Дараагийн дугаарт юу вэ гэхээр зэрэг энэ улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг Улсын Их Хурлаар батлуулах ёстой юм уу. Тэр нь батлуулсан юм уу, батлуулаагүй юм уу. Хуульд заасан зүйл хийгдээгүй байна гэдэг ийм байр суурийг бид нар бол илэрхийлж байгаа. Энэ тал дээр дэлгэрэнгүй мэдээлэл авмаар байна. Түрүүний хэлсэнчлэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл уг нь бол макро эдийн засгийн үндсэн

үзүүлэлтүүдийг боловсруулаад, тэдгээрийн барьсан энэ үзүүлэлтүүд дээр та бүхэн маань дунд хугацааны болон энэ богино хугацааныхаа төлөвлөлтийг хийх ёстой гэж хуульч.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 1 минут өгье.

Д.Пүрэвдаваа: Тэгэхээр энэ тогтвортой байдлын.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Хариулъя. Жавхлан сайд 3 номерын микрофон.

Б.Жавхлан: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Тэр үнэтэй холбоотой юмыг дахиад тайлбарлая. Энд нэг ийм 2 үнэ байдаг юм шүү. Төсөв төлөвлөхөд. Зах зээлийн үнэ, тэнцвэржүүлсэн үнэ гээд. Нүүрс дээр бол зах зээлийн үнэ 105, тэнцвэржүүлсэн үнэ 129 доллар. Тэнцвэржүүлсэн үнэ гэдэг ойлголт ер нь юу гэсэн үг вэ гэхээр уул уурхайгаас бид нар хэт хамааралтай, ийм савлагаатай, ийм орлоготой үед тэр хэт савлагааг нь цэвэрлээд тэнцвэржүүлсэн үнийг авдаг гэсэн ийм хуулийн дүрэмтэй юм. Ингэхдээ нүүрсний сүүлийн 20 жил, дараагийн 3 жил, тухайн жилийн гүйцэтгэлд гээд үндсэндээ 24 жилийн урт хугацааны түүхэн үнүүдийг дунджаар аваад, эндээс тэнцвэржүүлсэн үнээ гаргаж ирдэг гэсэн үг. Сүүлийн жилүүдэд нэлээн өндөр бүр 200 доллар ч хүртэл гарч байсан учраас тэр үнүүд нь нэлээн дээшээ татаад ингээд тэнцвэржүүлсэн үнэ 129 доллар, 105 доллар нь бол зах зээлийн үнэ. Яг бодит үнэ гэсэн үг. Тэгээд төсөв дээрээс харахаар 129-өөр тооцож байгаа мэт харагдаад байгаа байх. Ингээд төсвөө харах юм бол энэ чинь 105-аар нь байгаа. 105-аар нь тооцоод төсвийн 33,8 их наяд гээд байгаа тэнцвэржүүлсэн орлогоо бүрдүүлэхэд бид нар 105-аар авна. 105-аар авна. Давсан тохиолдолд төсвийн нэмэлт орлого болж ирнэ. 129-өөс дээш давах юм давсан хэсгийг нь Тогтворжуулалтын сандаа бид нар хадгалдаг гэсэн үг. Тэгээд бид нар аль

бага үнээр нь төсвийнхөө тэнцвэржүүлсэн орлого авдаг байхгүй юу. Тэгээд тэр тогтворжуулалтын санг жишээ нь бид нар юунд ашигладаг вэ гэхээр төсвийн тухайн энэ бүтээгдэхүүнээс шалтгаалсан орлого 20 хувиар үнэ нь ч юм уу биет хэмжээ нь огцом унах юм бол тогтворжуулалтын сангийн хуримтлалаа энэ алдагдлыг нөхөхөд ашигладаг. Үгүй. Энэ чинь 2025 оны бүрдүүлэх нэмэлт орлого байхгүй юу. Одоогоор хуримтлагдсан байгаа нь 1,6 их наяд. Хэрвээ 600-г бүрдүүлж чадах юм бол 2,2 их наядтай болно гэсэн үг. Энэ нүүрс дээр манайх үндсэн яг стратегийн 2 үндсэн бүтээгдэхүүн дээр өөрөөр хэлбэл төсвийн орлогыг 3 хувиас дээш бүрдүүлдэг 2 түүхий эд байдаг юм. Нүүрс, зэс 2. Зэс дээр үнэ нь бол яг эсрэгээрээ байгаа. Тэнцвэржүүлсэн үнэ 7491, зах зээлийн үнэ 10.000 доллар. Ингээд зах зээлийн үнэ 10 мянган доллар, 7491 байхад бид 7491-ээрээ авч байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл 10.000 доллароосоо бүр 25 хувь унаад 7500 дээр очиход бид нар энэ үнээрээ зэсээс орох орлогоо бүрдүүлээд, тэнцвэржүүлсэн орлогоо бүрдүүлээд, нөгөө төсвийнхөө урсгал зардлыг санхүүжүүлээд явах бүрэн боломжтой. Эрсдэлгүй гэсэн үг байхгүй юу. Тэгэхдээ энэ бүгд нийлнэ л дээ. Нийлээд.

Зэс дээр жишээ нь 7491-ээс давсан 10.000 доллар хүртэлх энэ үнийн зөрүүгээрээ Тогтворжуулалтын сан дээр орно. Тэр 608 тэрбумынх чинь 520 тэрбум нь зэсээс орно. 80 тэрбум нь буюу 129-өөс давсан хамгийн өндөр коксжсон 3 байдаг шүү дээ. Баяжуулсан кокс, сул баяжуулсан кокс, тэгээд хагас хуурай баяжуулсан кокс гээд 3 төрлийн кокс маань 129-өөс давахаар байгаа. Зах зээлийн хүлээлт нь. Энэ 3 коксоос орж ирсэн нэмэлт орлого маань Тогтворжуулалтын санд орох нь 80 тэрбум орчим байгаа. Ийм л юм байгаа. Одоо тэгэхээр ирэх жил бид үнийн зөрүүгээсээ хэрвээ үүсвэл бид энэ хэмжээгээр алдагдлаа нөхөх боломжтой гэсэн үг. Тэгэхдээ 3 тохиолдол байгаа.

Биет хэмжээ, үнэ 20 хувиас дээш унасан тохиолдолд, гуравдугаарх нь нийт тэнцвэржүүлсэн алдагдал маань бид нар 2 хувь гээд баталчхаад байна шүү дээ. Энэ 2 хувь биш бүр 4-өөс дээш хувь хувиараа гарах юм бол Тогтворжуулалтын сангаа алдагдлаа нөхөж болно гэдэг ийм заалттай. Энэ заалтуудыг Монгол Улс 2017 оноос хойш 2021 он хүртэл бол энийг бас ашиглаж байсан байдаг юм. Тэрнээс хойш бол бид ашиглаагүй. Хуримтлуулаад яваад байгаа. Одоо хуримтлал нь 1,6 их наяд дээр хүрчхээд байгаа ийм юм байгаа юм. Бусад тэр дефлятор болон төлөв.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Эдийн засаг, хөгжлийн яам 2 номерын микрофон.

Л.Энх-Амгалан: Гишүүний асуултад хариулъя. Жилийн төлөвлөгөөтэй холбоотой асуудал. Жилийн төлөвлөгөөг сонгуулийн өмнө яг хуулийнхаа хугацаанд Засгийн газраас өргөн барьсан Их хуралд. Их Хурал дээр бүх хэлэлцүүлгийг хийсэн. Хамгийн сүүлд эцсийн хэлэлцүүлэг хийгээд батлалгүй үлдээсэн. Төсөв бол жилийн төлөвлөгөө дээр үндэслэх ёстой. Тэгээд тэр агуулгаар нь жилийн төлөвлөгөөг дахин Их Хуралд өргөн барьсан. Сая сүүлд хийсэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулаад, тэгээд одоо яг хэлэлцээд явж байна. Төсвийн өмнө хэлэлцээд батлах ёстой. Одоо Эдийн засгийн байнгын хороон дээр хэлэлцээд явж байна. Тэр гишүүний хэлсэн зарим тоон дээр би бас хэлье. Манай Улсын эдийн засгийн өсөлтийг валютын сан 2025 онд 6 хувиар өснө гэж таамагласан байгаа. Дэлхийн банк бол 6.6 хувиар өснө гэж таамагласан. Монгол банк бол 7.3 хувь гэж хэлсэн байгаа. Засгийн газраас бол 8 хувь гэж оруулж ирсэн. 8 хувь гэдэг дээр бол төсөөллүүд яагаад зөрүүтэй гаргаад байдаг вэ гэхээр...

Ц.Даваасүрэн: Тогтвортой байдлын зөвлөл хэд гэсэн билээ. 6.6. Дэлхийн банктэй л ижилхэн юм байна.

Ер нь 8 л юм байна шүү дээ. Ганбаатар гишүүн асуултаа асууя. За хариулаад дуусгачих.

Л.Энх-Амгалан: Зөвлөлийн тоонуудыг авч хэрэглээгүй. Тэр үнэн. Зөвлөлийн тоонуудыг авч хэрэглэх гэхээр болохгүй байсан болохоор л авч хэрэглээгүй. Нүүрсний экспортыг 50 сая тонноор ...

Ц.Даваасүрэн: Тэгэхдээ харгалзсан юм байгаа биз дээ.

Л.Энх-Амгалан: ... экспортолно гэж үзээд бид хэд төсөөллөө хийчихвэл зах зээлийг тэр хэмжээгээр л жижгэрүүлнэ л гэсэн үг. Тэгэхээр заавал тэр чинь зах зээл дээр ч угаасаа буруу дохио болж өгнө гэсэн үг. Тийм учраас зөвлөлийн тоонуудаас ер нь авч ашиглаагүй байгаа. Тэр хөдөлмөрийн насны хүн ам буураад байгаа гэдэг бол л бас буруу мэдээлэл байна. Энэ бол өсөж байгаа. Хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой ажиллах хүчний оролцооны түвшин гэж нэг үзүүлэлт байдаг. Энэ бол ковидын үед буурсан. Ажил хийх ёстой 100 хүний хэд нь ажил хийж байна гэхээр манайд бол 60 нь ажил хийдэг юм. Гэтэл бусад улсуудын дунджаар 65-70 нь ажил хийдэг. Ковидын үед бол энэ үзүүлэлт манайд 57, 56 болж буурсан. Одоо буцаад сэргээд 61 болсон байгаа. Цаашидаа бол бусад улсуудын түвшинд хүрэхэд бол хөдөлмөрийн зах зээл орон зай байгаа юу гэвэл тийм.

Ц.Даваасүрэн: Ганбаатар гишүүн асууя.

Ж.Ганбаатар: Гадаад валютын нөөцийг 10 тэрбум долларт хүргэнэ гээд зорьж байгаа. Тэгээд Эдийн засгийн яамнаас асууя. Энэ биржээр нүүрс арилчихгүй байна л даа. Түрүүн би Эдийн засгийн байнгын хороон дээр асуусан юм. Тэгээд асуулт сайн сонсоод, тэгээд хариулаарай гэдгийг хэлье. “Эрдэнэс Тавантолгой” компани эхний хагас жилд, энэ оны эхний хагас жилд нийт

экспортлолсон нүүрснийхээ 70 хувийг биржээр зарсан байна. Тэрнээс хойш өнөөдрийг хүртэл 4 сар уу, 3 сар уу, энэ хооронд нийт экспортлолсон нүүрснийхээ 17 хувийг биржээр заржээ. Сангийн яам аа, Эдийн засгийн яам аа. Тэгээд яаж тэр Монгол Улс ерөөсөө Монгол Улсын валютын нөөц нэмэгдсэн гол зүйл бол ерөөсөө л биржээр нүүрсээ зарсны ач холбогдол шүү дээ. Одоо мэдэхгүй байна зүгээр. 17 хувь. Би энэ тоог өөрөө гаргаагүй шүү. Уучлаарай би яриадах уу. Тэгээд дундаж үнэ нь болохоор 90-95 доллар байна Жавхлан сайд аа. Сүүлийн хагас жилийн дундаж үнэ. Өмнөх улирлын, өмнөх хагас жилийн дундаж үнэ нь 140 доллар байсан байна. Биржийн дундаж үнийг л ярьж байгаа шүү дээ би. Биржийн дундаж үнэ. Түүнээс тэр хувийн компаниудын үнийг бол би мэдэхгүй байна. Тэгээд л биржийн дундаж үнэ 140 доллар байсан байна. Өнөөдөр 96 доллар болж. Яах вэ, жилийн хагаст өсөж магадгүй байх. Тэгэхдээ энийг бол мэдэж байгаа биз дээ л гэж хэлж байгаа юм. Тэгэхээр яагаад биржээр нүүрсээ зарахгүй байгаа юм бэ. Тэгэхлээр нөгөө дөрөвхөн компани байгаа. Хэрвээ бирж гэрээ байгуулахгүй байгаа гэж би итгэж байна. Гэрээ байгуулбал наадах чинь том асуудал үүснэ шүү дээ. Өмнөх юм руугаа халтирна гэсэн үг. Тэгэхээр тэр гэрээ байгуулахгүй байгаа нь гэхээр тэр 4 компани зарж байна. Тэр 4 компани чинь мөнгөөр авахгүй шүү дээ. Дандаа өрөндөө авна. Тэгэхээр энэ Монгол Улсын эдийн засаг, валютын нөөц хаашаа явах вэ. Ингээд дээгүүр сэлээд байх юм. Тэгээд намайг асуухаар тэр Наранцогт хариулж байгаа нь болохоор дунджаар 50 хувь байгаа гээд өмнөх хагас жилийн амжилтыг дараагийнхаа тэр 17-той нийлүүлбэл тэр чинь тэгээд 50 хэд гарна шүү дээ. Ойлгомжтой. Тэгэхээр өмнөх хагас жилд байсан 70 хувь чинь нэмэгдэх ёстой байхгүй юу. Тэрнээс гадна хуульд 100 хувь гээд заачихсан байгаа юм. Биелүүлэх ёстой. “Эрдэнэс Тавантолгой” компани. Хувийн компани бол хамаагүй шүү дээ. Сайн дураараа.

Тэгээд дээрээс нь зэс зарагдахгүй байна. Зэсийг биржээр зарах ёстой. Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүх намайг сайд болсны дараахан энэ “Эрдэнэт”-ийн зэсийг биржээр зармаар байна гэж хүсэлт тавьсан. Тэгээд сая Жавхлан сайд хэлж байна шүү дээ. 10 мянган доллар хүрчихсэн. Тэгээд зэсээ 2 удаа амжилттай.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Манай гишүүнийг сайд байх үед 145 байсан нүүрс яагаад сая 90 мянга болчихов. Хариулъя 3 номерын микрофон.

Б.Жавхлан: 6 сар дуусаад, 7 сар гарах хүртэлх тоонуудыг бол манай Ганбаатар сайд өөрөө сайн мэдэж байгаа байх. Би сая биржээс авсан мэдээ шүү. Ингэж байна. Өнгөрсөн оны эхний 9 сарын байдлаар нүүрс өнгөрсөн оных шүү 9 сарын байдлаар 7.468.800 тонн нүүрс биржээр арилжсан бол 9 сарын 26-ны байдлаар 17.734.400 тонн нүүрс арилжсан байна. Өнгөрсөн оныхтой харьцуулахад бол нэмэгдсэн байна. 7 сарын эхний хагасын тоог бол Ганбаатар сайд сайн мэдэж байгаа. Тэрнээс хойш нэмэгдсэн энэ 7 сар, 7 сарын сүүлийн хагас, 8 сар бүтэн, 9 сар бүтэн гэхээр тэр хэмжээнд гарсан.. та сая хэд гэсэн бэ 1,7 гэсэн үү. 17 хувь нь гэдэг бол 1 улирлын хувьд 17, тэгээд яг бага байдаг үе нь гэх юм бол 7, 8, 9 сар 3 сарынхаар бас нэг айхтар бүр яг гараагүй ч гэдэг юм уу, эсвэл уначихсан гэдэг юм уу ийм тоо би биш болов уу гэж ингэж бодож байна. Зүгээр энийг судлах хэрэгтэй. Би энэ талаар бас таныг асуугаад байхаар Туваан сайдад бас хэлсэн байгаа. Энэ мэдээнүүдээ бүгдийг нь гаргаарай. Бирж дээрээс бид нар гаргах мэдээнүүдээ гаргана гээд. Тэгэхээр бирж бол үйлчилгээ үзүүлж байгаа байгаа байгууллага. Санхүүгийн зуучлагч байгууллага. Энэ дээр жишээ нь төмрийн хүдэр бол эрс нэмэгдсэн байгаа. Та тэрийг мэдэж байгаа. Төмрийн хүдэр бол эрс нэмэгдсэн. Тэр зэсийг би бол хэлж мэдэхгүй байна. Төмрийн хүдэр дээр жишээ нь Дархан дээр болж байгаа

юмыг би сайн мэдээд байгаа. Өмнөх арилжаалсан арилжааныхаа хүдрүүдийг нөгөө тэврээсээ болоод хил дээрээ хүргэж өгч чадахгүй учраас дараагийнх нь арилжааг нь биржээс чинь хүлээж авахгүй байгаад байгаа юм байна лээ. Дарханыхыг жишээ нь. Зүгээр үүнтэй адилхан тийм нэлээн олон жишээнүүд байгаа болов уу. Зүгээр зэс дээр харьцангуй гайгүй л байх ёстой. Зэс дээр юу болоод тэгсэн юм бол би хэлж мэдэхгүй байна. Энэ бол “Эрдэнэс Тавантолгой” энэ дээрээ их сайн хариулах байх. Бирж бол ирснийг нь арилжаалах үүрэгтэй. Ингэхдээ бол нэлээн тийм босго тавина. Өмнөх явсан арилжаанууд маань яг хугацаандаа яг амласан, арилжсан тэр индексийнх нь нүүрс нь жишээ нь яг тэр лот дээрээ хугацаандаа очсон уу, үгүй юү. Тэгж байж дараагийн арилжаанууд нь явдаг байгаа. Ийм шаардлагуудаа бол тавиад явж байгаа. Тэгэхээр бол зогсчихсон ч гэдэг юм уу, эсвэл буурсан гэдэг юм уу тийм тоо бол биржээс ирсэн мэдээ дээр харагдахгүй л байгаад байна. Өөр нэмэлт мэдээллүүд байвал Эдийн засаг, хөгжлийн яам өгөх үү юу.

Ц.Даваасүрэн: Биржээр зарахгүй гэхээр чинь гэрээгээр зараад байгаа гэсэн үг үү. 2 номерын микрофон.

Л.Энх-Амгалан: Биржтэй холбоотой эхний хагаст бол биржээр нүүрс сайн зарагдаж байсан. 4, 5 сард бол сард дунджаар 4 саяыг зарж байсан. Тэгээд 6, 7, 8, 9 сарын дундаж бол сая хүрэхгүй байна. Биржээр зарагдаж байгаа хэмжээ. Гэтэл оны сүүлийн хагаст бол төмрийн арилжаа маш сайн байна. Оны эхэнд сард дунджаар 100 мянган тонн төмөр арилждаг байсан бол одоо 400 мянган тонн.

Ц.Даваасүрэн: Эрэлт нь буурчхаад байгаа юм уу. Нүүрс яагаад тэгээд байгаа юм.

Л.Энх-Амгалан: Нүүрс дээр бол яах вэ үнэ жаахан буурчихсан. Тэрэнтэй уялдуулаад...

Ц.Даваасүрэн: Биш ээ, биш. Яагаад хэмжээ нь бага 4 сая байсан. Харин яагаад тоо хэмжээ багасчхав гэж байхгүй юу.

Л.Энх-Амгалан: Тоо хэмжээ багасахдаа яах вэ, компаниудын хэлж байгаагаар бол оны эхний хагаст үнэ өндөр байсан. Үнэ өндөр байхад бодлогоор арилжаагаа сайн хийж авсан. Үнэ буурсан учраас бид цаад талаасаа нийлүүлэлтээ бас жаахан бууруулсан.

Ц.Даваасүрэн: Тэрнээс биш гэрээгээр яваад байгаа юм байхгүй юм байгаа биз дээ. Байгаа юм уу.

Л.Энх-Амгалан: Хуулиараа бол төрийн өмчит компаниуд зөвхөн биржээр зарах ёстой. Биржээр зарагдаагүй шинэ гэрээ огт хийгдээгүй байгаа.

Ц.Даваасүрэн: Тодруулъя Ганбаатар гишүүн. Жавхлан гишүүн 3 номер

Б.Жавхлан: Энэ дээр бол “Эрдэнэс Тавантолгой” орон нутгийн “Тавантолгой” ч гэдэг юм уу, Монросцветмет гээд энэ экспорт хийдэг төрийн өмчийн оролцоотой компаниуд маань биржийн бусаар гэрээ хийж лав хилээр, гаалиар гаргаж чадахгүй. Ямар ч боломж байхгүй. Гааль, татвар, тухайн компани 3 холбогдсон системтэй байгаа. Гэрээг тэндээ системдээ оруулна. Татвар дээр очно. Татвараас эцсийн зөвшөөрөл гааль дээр очно. Тэгж байж гааль цаашаа гаргаж байгаа юм. Ийм системд орчихсон учраас ямар ч боломж байхгүй. Тэр бүү хэл нөгөө дотоодын биржийн биш, дотоодын арилжаагаар бага агуулгатай түүхий эдүүдийг дотоодын компаниуд арилжаалаад, нөгөөдүүл нь нэг нүд хуурсан юм шиг 1, 2 хувийн баяжуулалт хийгээд гаалиар

гаргах гэж байгааг хүртэл зогсоож байгаа. Тийм учраас тэр биржгүйгээр гаалиар гаргана гэдэг ойлголт бол байхгүй. Энийг бол би бүр хариуцлагатай хэлэхээр байна.

Ц.Даваасүрэн: Ганбаатар гишүүн тодруулъя.

Ж.Ганбаатар: Би өөрөө ажлын хэсгийг нь ахалж байсан юм чинь наадахыг чинь сайн мэдэлгүй яах вэ дээ.

Ц.Даваасүрэн: Ганбаатар гишүүний микрофоныг өгье. Энэ микрофон нь яагаад байна. Техникийнхээ юмыг зохицуул даа. Яагаад байна.

Ж.Ганбаатар: Болж байна уу. Эхний хагас жилд наадах чинь биржээр нүүрсээ бид хангалттай зарж байсан. Эдийн засаг, хөгжлийн яам, Уул уурхай яам хариуцаад энэ чинь ажлын хэсгээ ахлаад Жавхлан сайдын хэлээд байгаа бүх л процессуудыг бид шахаж ажиллаж байгаа шүү дээ. Сүүлийн хагас жилд, одоо хагас жил биш л дээ энэ чинь 4 сар болж байна уу. Энд чинь биржийн арилжаа уначхаад байна. Энэ чинь хуулиараа наадах чинь 100 хувиа зарах ёстой шүү дээ. Унах биш. Уначихсан байж магадгүй ч гэх шиг. Уначихсан байх ч гэх шиг. Унах ёсгүй. Өсөх ёстой. Хуульд 100 хувь шүү дээ. Ноднингийн мөн үетэй харьцуулна. Наадах чинь өмнөх хагас жилийнх нь дүнг сүүлийн хагас жилийнхээ муу дүнтэй харьцуулаад дундаж гаргаж хариулаад байна шүү дээ. Тийм байж болохгүй байхгүй юу. Одоо наадах чинь өсөх ёстой байхгүй юу. Дээрээс нь тэр 4 компани чинь бэлэн мөнгөөр нүүрс авахгүй шүү дээ. Тэгээд би бол биржээр биш нүүрс зарж байна гэж хэлэхгүй байна. Биржгүйгээр нүүрс зарж байна гэж яриагүй байна. Яагаад биржээрээ нэмэгдүүлэхгүй байгаа юм бэ. Яагаад тэр гэрээтэй, тэр хуучин гэрээтэй айлуудаараа зараад байгаа юм бэ. Тэр валютынхаа нөөцийг нэмэгдүүлээч гэж хэлж байна шүү. Тэр 4 айл байгаа. 4 айлыг би мэдэж байна.

Хятадын томоохон 4 компани. Тэр 4 компани руугаа өгөөд байгаа юм байна л даа. Учиргүй тэгээд биржгүйгээр нүүрс зарж байна гэж мэдэхгүй байж тийм юм яриагүй байна. Тэр гэрээтэй 4 айл руугаа өгөөд байна гэдэг чинь Монгол Улсын валютын нөөц нэмэгдэхгүй л гэсэн үг. Тийм өрөнд явна. Тэгэхээр наадах чинь тэгээд энэ тоо баримттайгаа нийцэхгүй байна шүү дээ. Тэрийгээ шахаж ажиллаач ээ. Хэрвээ хангалттай хариулт өгчихвөл би чуулган дээр дахин дахин яриад байх сонирхол алга. Сая Эдийн засгийн байнгын хороо дээр үнэхээр хангалттай хариулт авчихсан бол би энэ дээр орж ирээд дахин ярихгүй шүү дээ. Тэгээд ойлголоо гээд л гараад л явна шүү дээ. Нэг их тэгээд л баатар болох гэж байгаа юм шиг би тэгдэг ч хүн биш. Тэгэхээр наад биржийн чинь үйл ажиллагаа чинь үнэхээр буучхаад байна. Энэ дээрээ анхаараад, наад зохион байгуулалтаа нэмээч ээ. Орлого чинь дутах нь ээ. Энийгээ анхаараач ээ л гэж хэлж байна. Би өөрөө хийж байсан ажил шүү дээ наадхыг чинь. Хүрэлбаатар сайд маш сайн ажилласан. Шахаж байж явдаг ажил. Тэгэхгүй бол Хятадын тал эсвэл Монголын тал баахан шалтаг л тоочно. Тэр зэс дээр гэхэд 2 удаа амжилттай арилжаа хийчхээд байхад, ахиад шалтаг тоочоод хийхгүй байна шүү дээ. 7 сар, 8 сар, 9 сар. Тэр шалтаг битгий тоочооч ээ, ажлаа хийгээч ээ л гэж байгаа юм. Түүнээс биш тэрийг нэг их айхтар тэр биржгүйгээр нүүрс зарчихлаа гэсэн юм бол алга байна. Ажлаа сайжруулаад л тэгээд биржээр нүүрсээ зар. Тэр хуульд чинь 100 хувь гээд заачихсан юм чинь. Төрийн өмчит үйлдвэр 100 хувь биржээр нүүрсээ зарах ёстой. Төмрөө зарах ёстой. Зэсээ зарах ёстой. Үгүй ээ, тэрийг чинь ингээд жил нь гүйцчихсэн байгаа байхгүй юу. Хугацаа байхгүй юу. Уучлаарай. Баярлалаа. Дууслаа. Би юм асуусангүй шүү. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Түрүүн гацаад байсан учраас бас давуу эрх олгочихлоо. Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Эдийн засгийн яамнаас асуумаар байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс энэ төсвийг нээлттэй хэлэлцүүлэг хийгээгүй байна гээд тавьчихаж. Энэ зөв л дөө. Тэгэхээр энэ дээр бас нэлээн юмнуудыг олон нийтэд өгөхгүй бол энэ төсөв чинь өөрөө олон нийтийн хүлээлтийн асуудлууд байгаа юм. Төсөв маань нэмэгдээд байдаг. Бүтээн байгуулалтууд хийлгүй яах вэ дэмжиж байгаа. Гэхдээ ирэх жил ер нь бол тодорхой нийгмийн чиглэлийн зардлууд бол танагдаж байгаа ийм асуудлууд бол байгаа. Дээрээс нь баахан томоохон бүтээн байгуулалтыг бараг 60 хувь нь гадна, дотнын хөрөнгө оруулалт, зээл, тусламжаар авна гээд тавьчихсан. Тэгэхээр яах вэ, энийг өмнөх түүхийг давтах вий гэдэг дээр яах вэ бас санаа зовж байгаа бүлэг хүмүүс байна. Бид нар чинь 2016 онд, 2017 онд ОУВС-ийн деполтын хөтөлбөрт өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт ороод тэр дээр юу гэж тайлбарлаж байсан бэ гэхээр баахан зээл авчихсан тэрийгээ төлөхөөс өөр арга байхгүй. Тэрнээсээ болоод нийгмийнхээ зардлуудыг танахаас өөр арга байхгүй гээд нийгмийн тогтворгүй байдал бас үүсэх гээд байсан. Тэгэхээр энэ удаагийн Их Хурал ирэх 4 жилийн хугацаанд өнөөдрийн төсөвт оруулж ирж байгаа томоохон бүтээн байгуулалт, зээл, хөрөнгө оруулалтын асуудлууд эргээд төлнө гэсэн үг зарим нь. Эргээд ийм эрсдэл учруулах уу, үгүй юу гэдэг дээр манай Эдийн засгийн яам ямар тооцоо судалгаа хийж байгаа юм бэ. Хүмүүсийн хүлээж байгаа юм ерөөсөө миний орлого яаж нэмэгдэх вэ л гэж хүлээж байгаа шүү дээ. Тийм учраас энэ тал дээр бол эцсийн үр дүн бол үүгээр би хэмжигдэх болов уу гэж харж байгаа.

2 дугаарт нь, Сангийн яаманд бас би дахиад өчигдөр бас бүрэн тодотгож хэлж амжаагүй. Макро эдийн засгийн гол үзүүлэлтийн цалингийн суурь үзүүлэлт, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гээд байгаа. Энийг ерөөсөө ямар ч өсөлтгүйгээр оруулаад ирчихсэн байна

лээ. Нэмэлтгүйгээр оруулаад ирчихсэн байна лээ. Нэмэхгүй гээд. Одоо манайх чинь цагийн 1 доллар 20 цент л байгаа шүү дээ. Сүүлийн бараг 10, 20 жил л иймэрхүү байсан. Сүүлийн жилүүдэд жсоохон, жсоохон өсгөөд, арай гайгүй дорвитой өсгөсөн. Тэгэхээр энийг 2 жил тутамд ингэдэг. Жил болгон бага багаар нэмээд явъя гэдэг нэг ийм хэлэлцээр байгаа. Нийгмийн түншлэлийн. Тэгээд энийгээ энэ жил бид нар чинь зунжингаа сонгуулалдсаар байгаад, тэгээд хөдөлмөрийн хөлснийхөө доод хэмжээг л нэг шийдэх гэж байгаа. Тэгэхээр энэ дээр манай Сангийн яамныхан тооцоолол оруулж ирээд, хэрвээ ойролцоогоор 20 орчим хувь, 21, 22, орчим хувь нэмэх болов уу гэдэг ийм юм байгаа. 800 болох буюу 1.37 цент буюу 17 центээр цаг тутмыг л нэмье гэж байгаа юм. Түрүүн тэр ажиллах хүчний юу асууж байна. Манай ажил чинь Солонгос руу яваад байгаа. Солонгосын цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг сая 8 доллар болгочихсон байна лээ. Тэгэхээр цаашидаа бид нар 1 долларын л хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй гэж яваад байх уу. Энэ тал дээрээ тооцооллоо хийхгүй бол бас асуудал байна.

Дээрээс нь би сая Эдийн засгийн яаманд хэлж байгаа нь Эрүүл мэндийн сан, Нийгмийн даатгалын сан бас хүндэрч байна гээд яриад байгаа. Энэ чинь нөгөө талд нэг үзүүлэлт нь болоод байгаа юм. Хүмүүс хамгийн багаар төлөөд тэгсэн ч ялгаа байхгүй үйлчилгээгээ авна. Хамгийн багаар төлж байгаад, хамгийн сүүлийн 5 жилээ хамгийн өндрөөр төлж байгаад, өндрөөр тогтоолгож байгаа хэсэгт нь хожоод.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Эдийн засгийн яамнаас асуусан юм уу. 2 номер. 3 номер Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Бид нар шинэ цаглаварт ороод 9 сарын 1-нд төсвөө өргөн барьдаг болсон. Бид нар өргөн

барих мөчид 3 талт хэлэлцээрээс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ийнхүү өсгөлөө. Энийг төсөвт өргөн барина уу ч гэдэг юм уу ийм хүсэлт ирээгүй Эрдэнэбат дарга аа. Та өөрөө энийг маш сайн мэдэж байгаа шүү дээ. 3 талт гэрээгээр шийдээгүй юмыг бид нар дур мэдэж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Засгийн газар, Сангийн яам мэдэж оруулна гэж байхгүй шүү дээ. Та маш сайн мэдэж байгаа. Яагаад энийг ингээд байн байн асуугаад байгаа юм. Хэрвээ одоо ингээд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэнэ гээд 3 талт хэлэлцээр хэрвээ болоод ингээд шийдвэр ирэх юм бол Их Хурал дээр хэлэлцэх бас сонголт байгаа. Тэрийг өөрөө та маш сайн мэдэж байгаа. Тэгээд яах вэ, нэгэнт энэ сэдэв хөндөгдсөнийх ажил олгогч талаас энийг бас нэлээн хүнд цохилт болоод байгаа шүү дээ энэ асуудал. Сүүлийн жилүүдэд бид ковидын жилүүдэд бид нар нэмж чадаагүй цалингуудаа төрийн албан хаагчдын цалингуудыг бол сүүлийн 2 жилийн хугацаанд бид нар сайн нэмсэн. Сайн нэмсэн. Бүр нөхөж нэмсэн. Энэ бол яг ажил олгогч хувийн хэвшлийнхэн дээр бол нэлээн дарамт болж очиж байгаа. Нэлээн чирч байгаа. Тийм учраас танайхаас тавьж байгаа энэ шаардлагуудыг ажил олгогч талаас бол огт дэмжихгүй, хүлээж авч чадах боломжгүй гээд. Засгийн газар талаас бид нар сүүлийн жилүүдэд нэлээн сайн нэмчихсэн учраас энийг бас дахиад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дээш нь татаад, хувийн хэвшлээ бас дахиад энийг ингээд сунгах бас маш өндөр эрсдэл учраас боломжгүй байна гэдэг тал дээрээ байгаа. 3 талт хэлэлцээр болсон ч гэсэн энэ дээр бол манай байр суурь би хэвээрээ байх болов уу гэж ингэж би Хөдөлмөрийн яамныхаа өмнөөс хэлчихлээ шүү. Ийм зүйлүүд байна.

Ц.Даваасүрэн: 2 номерын микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Гишүүний хэлэлцүүлэг хийсэн үү гэдэг асуултад

хариулъя. Төсвийн хүрээний мэдэгдлийг 6 сард баталсан. 5 сарын 1-нд өргөн барьсан. Хуулийн дагуу 3 сарын сүүлээр 3 сарын 28, 29-ний үед хэлэлцүүлэг хийсэн байгаа. Хэлэлцүүлэгт Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн бүгд оролцсон. Сүүлд бол Төсвийн хүрээг өөрчлөх шалтгаан бол Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт орсноор энэ хуулийг өөрчлөх шалтгаан болсон. Сүүлд батлагдаад тэр нь төрийн мэдээлэлд хэвлэгдээд гарч ирснээс хойш энэ оруулж байгаа өөрчлөлттэй холбоотойгоор хэлэлцүүлэг хийх хуулийн хугацаандаа багтах боломжгүй байсан болохоор яг нэмэлт, өөрчлөлт дээр бол хэлэлцүүлэг хийж чадаагүй байгаа.

Ц.Даваасүрэн: Тодруулах юм уу Тодруулъя Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Энэ санаатай ч юм ишиг нэг юм хийгээд байгаа юм. Засгийн газар ажил олгогч нь өөрсдөө ингээд хэлэлцээр хийгээд зугтаачихдаг. Тэгэнгүүтээ хэлэлцээр хийгээгүй юм чинь нэмэхгүй гээд ингээд байдаг. Тэгэхээр энэ өөрөө юуг хэлээд байна вэ гэхээр эргээд маргаан үүсэх вий. Энийг чинь хүлээгээд байж байгаа би бас нөгөө талдаа эрүүл мэнд, нийгмийн даатгал буюу өртгийн жинтэй нь тэнцүүлээд суурь юмнууддаа жсоохон өөрчлөлт хийж явж байхгүй бол бусад санд чинь нөлөө үзүүлдэг хүлээлт байсан юмнууд үлдчихээд байгаа учраас бас би энийг хэлээд байгаа юм. Дээрээс нь тэр хэлэлцүүлэг гэдэг дээр энэ саяын энэ асуудлуудаа сайн тэр тухайн тухайн салбар юунууд дээр нь хийж байхгүй бол олон нийт чинь энэ төсөвтэй холбоотой асуудлаар бас бүрэн мэдээлэл алга. Баахан байшин барилга л барих гээд байгаа юм байна. Зам тавих гээд байгаа юм байна. Тэгээд өөр цалин тэтгэвэр юу ч байхгүй байгаа юм байна. Эд нар ингэж байна гэдэг л юм байгаа учраас би энэ дээр бас болгоомжилж энэ төсөв дээр хийх гээд байгаа энэ юмнуудаа бас нэг хийж байгааг ээ гэдэг талаас нь ярьж байгаа юм шүү. Жавхлан сайдын тэр юу

гэвэл ингээд өнөө маргаашигүй шийдчихээр 9 сарын 1-ээр бандан тас гээд явчих гээд байна уу.

Ц.Даваасүрэн: Асуулт асууж дууслаа. Тэгэхдээ сая хэлсэн зүйлүүдийг дараагийн 2025 оны төсвийн тухай хэлэлцүүлэг дээр яригдана гэдгийг бас анхаарч бэлдэж, дэлгэрэнгүй хариулт өгөхөд анхаараарай. Ялангуяа саяын тэр Ганбаатар гишүүний яриад байгаа нүүрстэй холбогдолтой асуудлууд. Үнэ буурсантай холбогдуулаад нийлүүлэлт буурсан байж магадгүй л дээ. Тэгээд тэрийгээ сайн нарийн тайлбарлаад ингээд яахгүй бол сүүлийн хагас жилд биржээр борлуулаагүй юм байна гэдэг ийм ойлголт бас төрчих шиг боллоо. Ер нь зүгээр манай Эдийн засгийн яамныхан энэ эдийн засгийн макро үзүүлэлтээ гаргахад бас түрүүний миний хэлсэн зүйлийг жоохон анхаарч байх хэрэгтэй юм байгаа юм. Яг үнэн чанартаа экспортын орлого дээр бол Оюутолгойн борлуулалт бол маш том дүн харагдаж байгаа. Бараг 15 хувь. Хий том тоо. Экспорт маш их өсчихсөн харагдаж байгаа. Ялангуяа энэ алтны үнэ өсөж байгаа энэ үед маш том өсөлтийг авчирч байгаа. Гэхдээ манайд орж байгаа нь 200 сая доллар байхгүй юу. 200 сая доллар. Тэгээд харин энэ дээр зүгээр Сангийн яам нэг зүйлийг анхаармаар юм байна лээ Жавхлан сайд аа. Тэр хуучин бол ингээд гарч байгаа агуулгыг нэлээн сайн лабораториор хянадаг байсан юм. Одоо хянахаа больсон байна лээ. Алтыг. Тэр нөгөө Оюутолгойн гарч байгаа баяжмалыг. Тэрийг та бүр тэр гаалийн, тэгээд улсын лабораторийн тэр юуг нь бүр давхар баталгаажуулж байж гаргадаг байхгүй бол одоо жоохон алт алдахад л асар их мөнгө алдаж байгаа шүү дээ. Тийм учраас тэд нарын бэлдэж тавьж байгаа тэр уутанд биш, өөрсдөө дээжээ сонгож байгаад тэнд агуулгыг нь тодорхойлдог болох хэрэгтэй шүү. Үгүй ээ, нэг компаниар Монгол Улс ингээд дээрэлхүүлээд суугаад байдаггүй байж болохгүй шүү дээ. Тийм учраас энэ дээр нэлээн анхаарахгүй бол нөгөө асуулт

дуусчихсан юм чинь. Тэгэхээр энэ мэтийн зүйлүүдийг бид нар бас дараагийн хэлэлцүүлгүүд дээр бол асуух нь гэдгийг бас анхаараарай.

Үг хэлэх гишүүд байвал нэрээ өгье. Ингээд Дамдинням гишүүнээр тасаллаа. Заяабал гишүүн үг хэлье.

Б.Заяабал: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр бид нар төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэж байна. Төсвийн байнгын хороо Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар орсон сүүлийн 2 жилийн өмнө билүү, 1 жилийн өмнө орсон энэ том өөрчлөлт бол энэ Төсвийн тогтвортой байдлын байдлын зөвлөл гэж Улсын Их Хурал ялангуяа энэ Төсвийн байнгын хорооны дэргэд ийм мэргэжлийн багийг ажиллуулах болсон. Өнгөрсөн төсвийн тодотгол, одоо орж ирж байгаа төсвийн мэдэгдэл, төсвийн төсөл, дээрээс нь төсвийн хүрээний мэдэгдэл гээд эд нар дээр бол ингээд мэргэжлийн энэ байгууллага маань дүгнэлт ирүүлж байгаа юм. Энэ дүгнэлтийг бид нар ерөөсөө ойшоож анхаарахгүй яваад байна уу даа гэсэн ийм бодол төрж байгаа юм. Тэгээд үүнтэй холбоотой зүгээр саналаа бас хэлэх гээд байгаа юм. Ер нь дараа дараагийн төсөвтэй холбоотой асуудал, төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой асуудлыг бид хэлэлцэхдээ эхлээд энэ Төсвийн тогтвортой байдлын дүгнэлтийг хэлэлцдэг бас ийм горимд өөрчлөлт оруулж ингэж явах нь зөв юм байна гэж ингэж үзэж байна. Тийм учраас гишүүд минь дараа дараагийн энэ төсөвтэй холбоотой хэлэлцүүлгүүд дээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг тусад нь хэлэлцдэг ийм горим дээр бас оруулах нь зөв болов уу гэсэн ийм саналыг бас санал хэлж байгаа дээрээ илэрхийлж хэлэх гэсэн юм.

2 дугаарт нь энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр өгсөн манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргаж ирсэн дүгнэлтүүдтэй би бас нэлээдгүй

санал нийлээд байна л даа. Нэлээдгүй санал нийлээд байна. Энэ төсвийн хүрээний мэдэгдэл үндсэндээ сайтар тооцож байгаад 3 жилийн тооцооллыг гаргадаг. Үндсэндээ дунд хугацааны төсвийн бүх бодлогыг гаргаж ирдэг. Энд нийцүүлээд жил жилийн төсөв боловсруулагдаж явдаг. Ийм зохицуулалт нь энэ Төсвийн тухай хуульд ч байгаа, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд ч байгаа. Гэтэл ингээд жил болгоны төсөв, төсвийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх болгонд төсвийн хүрээний мэдэгдлийг оруулж ирж ингэж явдаг энэ зүйлийг бид нар бас хэзээ засах юм бэ. Хэдэн сарын өмнө л энэ төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг арай өөрөөр тооцож байсан. Дахиад л ингээд л өөрчлөөд л оруулаад ирчихсэн. Манай гишүүд асуугаад байна шүү дээ. Энэ чинь зөв шүү дээ. Дээрээс нь яагаад ингэж өөрчлөлт оруулж ирээд байгаа юм болоо гэдэг дээрээ бас энэ манай төсвийн хүрээний мэдэгдэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн бас гаргаад ирчихсэн байна л даа. Жишээлбэл энэ эдийн засгийн өсөлтийг 8 хувь хүргэхгүй бол, хүргэж тооцож чадахгүй бол энэ төсвийн тэнцвэржүүлсэн орлого буурах, гадаад зээлийн хүүгийн төлбөр нэмэгдэх, нэмэгдэж болзошгүй ийм нөхцөл байдал байна. 8 хувь хүргэхгүй бол бас болохгүй. Ингээд төсөвтөө баригдаад ингээд бараг 8 хувь хүргэхчээ гэсэн ийм агууламж бүхий бас дүгнэлтийг бас оруулаад ирчихсэн байгаа юм. Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дээр бас анхаарах ёстой нэг гол анхааруулж хэлж байгаа зүйл нь энэ хос алдагдлын мөчлөгт бас орох ийм боломж, эрсдэл үүсэж байна шүү гэдэг ийм асуудлыг бас оруулж ирж өгсөн байгаа. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг 8 хувь нэмэгдүүлээд байгаа боловч энэ нь эдийн засгийг солонгоруулах төрөлжүүлэлт нь муу байгаатай холбоотой. Зөвхөн уул уурхайн сая жишээлбэл 8 хувь өсөж байгаа нь Оюутолгойн далд уурхайн олборлолт ихэссэнтэй холбоотойгоор нэмсэн юм гэдэг ийм зүйл ярьж байна

шүү дээ. Гэтэл эдийн засгийн өсөлт нь цаанаа эдийн засгийг нь солонгоруулах, эдийн засгийг нь төрөлжилт нэмэгдэхтэй холбоотой асуудал яригдаж байж. Энэ Монгол Улсын эдийн засагт бодитой эдийн засгийн өсөлт бий болох, ёстой, ажилтай орлоготой Монгол иргэдийн тоо нэмэгдэх ёстой. Үүнтэй холбоотойгоор ингээд төлбөрийн тэнцлийн асуудал, эдийн засгийн төрөлжилт муутай холбоотойгоор ийм хос алдагдлын мөчлөг рүүгээ орох ийм бас нөхцөл байдал үүссэн байна гэх мэтчилэн ийм нэлээн ноцтой, ноцтой дүгнэлтүүдийг өгсөн байгаа юм. Тэгээд манай манай гишүүд энийг бас анхаарч, дараа дараагийн төсвийн асуудал хэлэлцэхэд энэ тогтвортой байдлын.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Батбаяр гишүүн үг хэлье. Өнөөдрийн хурлаар энэ төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэх эсэх тухай ярилцаж байгаа. Гэхдээ дундуур нь бас энэ Монгол Улсын төсвийг бүрдүүлж байгаа нүүрсний борлуулалт биржээр борлуулж байгаа тухай нэгэнт яригдсан учраас яг энэ бирж дээр яг ямархуу асуудлууд болоод байгаа тухай авсан мэдээлээ бас хуваалцах ёстой байх гэж бодож байна. Ялангуяа Эдийн засаг, хөгжлийн яамны төлөөлөл байгаа. Сангийн яамны төлөөлөл байгаа учраас бас цаашидаа анхаараад явах ёстой болов уу гэж бодож байна. Тэгэхээр яагаад ер нь бол ул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр зарж эхэлсэн бэ гэхээр ил болгох, бүгдийг нь шилэн болгох, бүх нийлүүлэлт, борлуулалт, худалдан авал, зөөлтийг бүгдийг нь ил болгох зорилгоор биржээр борлуулж эхэлсэн байгаа. Эхний хугацаанд үндсэн зорилгодоо хүрээд явж байсан. Тэгээд сүүлийн хэдэн сарын турш борлуулалт огцом буурсан талаар Уул уурхайн сайд байсан хүн нь байнга ярьж байгаа. Тэгээд энэ учиртай юм байна лээ. Энийг цаашидаа анхаарах ёстой юм байна лээ. Юу вэ гэхээр бирж дээр борлуулж байгаа болон худалдан авч байгаа талууд аль аль нь оролцох ёстой байдаг юм байна. Брокерууд оролцох ёстой байдаг.

Гэтэл хуульдаа брокер байж болно гэсэн зүгээр байж болно гээд заагаад өгчихсөн учраас яг брокерууд яг энэ худалдан авах үйл ажиллагаанд нь оролцохгүй байгаад байгаа юм байна лээ. Тийм учраас эхний хэдэн борлуулалт хийгдчихдэг тэр борлуулалтууд маань өөрөө тээвэрлэлт нь хийгддэггүй, гацдаг, алга болдог иймэрхүү асуудлууд байнга гараад байгаа юм. Түрүүн Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн тухай бас ярьсан. Эхний хэдэн борлуулалт нь хийгдээд дараагийнх нь борлуулалт нь хийгдэхгүй худалдан авагч нар нь байхгүй болчихоод байгаа юм. Яагаад гэхээр худалдаж авсан бүтээгдэхүүнээ авч чадахгүй байгаа байхгүй юу. Брокерууд нь тэрийг хариуцаад бүх борлуулалтуудыг хийх ёстой байтал тэгэхээр юун дээр анхаарах ёстой вэ гэхээр яг энэ худалдан авах үйл ажиллагаандаа энэ биржийн үйл ажиллагаа дээр нь брокеруудыг оролцуулах ёстой юм байна. Шаардлагатай бол яг энэ Биржийн тухай энэ хуульд нь бас өөрчлөлт оруулах хэрэгтэй байгаад байгаа юм байна лээ. Эдийн засаг, хөгжлийн яамныхан энэ дээр анхаарч байж энэ уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр зарах энэ үйл ажиллагаагаа хэвийн түвшинд авч яваад, цаашилаад сайжруулах тухай ярих юм байна. Энэ талаар л анхаараасай гэж хүсье.

Ц.Даваасүрэн: Пүрэвдаваа гишүүн.

Д.Пүрэвдаваа: Түрүүн энэ микрофон гацаад бас хэлье гэсэн юмнуудыг хэлж амжаагүй юм. Ялангуяа энэ хууль дээр тодорхой заагчсан. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан батлуулах, жилийн төсвийн төслийг тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.11-д заасны дагуу батлагдсан төсвийн хүрээнд мэдэгдэлд нийцүүлэн

төлөвлөх үүрэгтэй гэгчихсэн байгаа юм. Тэгээд Эдийн засгийн яам тодотгол орж ирэх болгондоо, төсөв барьж орж ирэх болгондоо энэ төсвийн хүрээний мэдэгдлээ өөрчлөөд, макро эдийн засгаа бид нар ингээд төлөвлөж таамаглаж чадахгүй, эсвэл чадвар нь байж байгаа ...

Ц.Даваасүрэн: Техникийнхэн найдвартай ажиллах талаас нь анхаармаар байна.

Д.Пүрэвдаваа: Тэгээд Эдийн засгийн яам ер нь Улсын Их Хурлын гишүүдэд өгч байгаа мэдээллээ үнэн бодитой, үндэслэлтэй гаргаж өгмөөр байгаа юм. Тэгээд түрүүний тогтвортой байдлын зөвлөлөөс хараат бус мэргэжилтнүүдийн тоо баримтыг ашиглахгүй байгаа нь өөрөө зөрчил шүү дээ. Энэ байгууллагыг байгуулаад, хуулиараа эрхийг нь олгоод энэ тоо баримтыг ашиглаад төлөвлө гээд байхад эсрэг үйлдэл хийгээд байгаа чинь өөрөө зөрчил байхгүй юу. Тэгээд дараагийнх нь зүйл. Олон улсын энэ гаргаж байгаа тоо баримтууд Тогтвортой байдлын зөвлөлийн гаргасан 2025 оны төсөөлөлд чинь нийцэж байгаа байхгүй юу хоорондоо. Та бүхэн гаднын зээл тусламжийг л намчирхаж өөрсдийнхөө энэ эрх мэдлийг нэмэгдүүлэхийн төлөө энэ зээл тусламжаа гүйцэд ашиглахын төлөө дотоодын нийт бүтээгдэхүүнээ аль болохоор өөдрөгөөр л харж байгаа л үйл ажиллагаа шүү дээ. Тэгээд энийгээ няцаах хэрэгтэй шүү дээ. Хараат бус энэ Тогтвортой байдлын зөвлөлтэй энэ зөрөөд байгаа асуудлаа. Хуулийн хувьд дээрээс нь төлөвлөгөөгөө батлуулаагүй. Тэгээд Мөнгөний бодлого 10 дугаар сарын 1-нд бас Улсын Их Хурлаар орж танилцуулагдах ёстой. Төсөв болохоор 9 сарын 1-нд. Тэгээд мөнгөний бодлого чинь бас зөрөөд явчихвал яах вэ. Ингээд бодлого нь зөрүүтэй эдийн засагтай улс болчихоод байна шүү дээ. Бүх хүн нүүрсний чинь үнэ унах магадлалтай байна гэхээр зөвхөн Засгийн газрын түвшинд л нүүрс өснө л гэдэг.

Ц.Даваасүрэн: Ганзориг гишүүн.

П.Ганзориг: Ерөнхийдөө өмнөх гишүүдийн саналуудтай давхцаж байгаа. Тэгэхдээ бас тодотгоод бас хэлэх нь зүйтэй гэж бодож байна. Энэ төсвийн сая 2024 оны тодотгол ярихад, одоо ингээд 2025 оны төсвийн төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдэл ярьж байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг ер нь л харгалзаж огт үзэхгүй байна л даа. Тэгээд 2 агуулгаар би 2 зүйл хэлмээр байна.

Нэгд хуулийн асуудал байна. Тодорхой хуулийн шаардлагуудыг хангаагүй байна, ороогүй байна, зөрчөөд байна гээд байхад Засгийн газраас өргөн барихдаа Хууль зүйн сайд нь хуульд нийцэж байгаа гээд биччихэж байгаа урьд нь. Тэгэхээр одоо энэ дээр цэг тавихгүй бол бид нар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргасан дүгнэлт дээр байгаа хууль зөрчиж байгаа асуудлууд нь хамаатай юм уу. Тэгээд Хууль зүйн сайд нь зөрчөөгүй гээд л хэлчхэж байгаа бол тэрүүгээр нь явах юм уу гээд ойлгомжгүй байдал үүсэж байна шүү дээ. Тэгэхээр энийг тодорхой болгож явахгүй болохгүй юм болов уу. Бид нар бас өмнө нь Төсвийн байнгын хороон дээр ярьж байгаад, төсвийн тодотгол ярьж байхад Их Хурлын Тамгын газраас билүү дээ хууль зүйн дүгнэлт гаргуулъя гээд явуулж байсан. Иймэрхүү агуулгатай бас асуудлуудыг ярих ёстой болов уу гэж бодож байна.

2-т энэ хараат бус мэргэжлийн хүмүүсээ Их Хурал байгуулчхаад, төсвийнхөө сахилга батыг сайжруулах гэж нарийн бас мэргэжлийн хүмүүсийн дүгнэлт, саналуудыг бас тусгаж авч явах гэж дүгнэлт гаргуулчхаад, энийгээ ажлын хэсгээс танилцуулахдаа ганц ч макро тоог нь аваагүй гэж байгаа байхгүй юу. Тэгвэл ер нь үүний хэрэг байгаа юм уу. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдийг энд суулгаад, санал асуулт аваад байх шаардлагагүй болж таарч байна шүү

дээ. Огт хэрэггүй юм бол. Тэгэхээр яг мэргэжлийн хүмүүсийн өгчхөөд байгаа энэ дүгнэлтүүд дээр бол анхаарах ёстой зүйлүүд нэлээн байна. Яах вэ би давтагдахгүйн үүднээс 1 зүйлийг нь дурдъя. Энэ 2 дугаар хэсэг дээр төсвийг тэлэх орон зай гээд. Энэ дээр бол дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг 2025 онд авахдаа нэрлэсэн дүнгээр 20 хувиар өсгөчихсөн. Нэрлэсэн дүнгээр. Тэгэхдээ гол анхаарах ёстой зүйл юу байна вэ гэхээр ковидын өмнө эдийн засаг агшчихсан, ковидын үеийн дараагийн өсөлт дээр өндөр өсөлт харуулсан тэр хувь процентыг төсөөлж аваад, тэгээд агшчихсан эдийн засаг дээр өссөн өсөлтөөрөө сайн байх юм шиг төсөөлөөд авчихсан байх ийм эрсдэлүүд байна гээд огцом өснө гээд тооцчихсон байна гэж байгаа юм. Тэгэхээр яг иймэрхүү байдлаар бас яг нарийн тооцоолчихсон тооцоо судалгаатай хийчихсэн зүйлүүдийг сайтар харгалзаж хэлэлцэхгүй бас болохгүй байна. Мэдээж ирэх жилүүдэд 4 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө дээр хөгжлийн том хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлууд явж байгааг ойлгож байгаа. Дэмжиж байгаа. Тэгэхдээ тэрийгээ багтаах гээд...

Ц.Даваасүрэн: Энэ цаг нь гацчих юм. Тэгээд зарим дээр нь цаг нь явахгүй болчих юм.

П.Ганзориг: Тэр орон зайгаа бий болгох гэж ингэж хамаагүй бас өөдрөгөөр хий хоосноор төсөөлөх бас эрсдэлтэй. Ялангуяа урсгал зардал өсөөд 25 их наяд болчихсон явж байгаа шүү дээ.

Ц.Даваасүрэн: Энэ цагийг нь зохицуулъя. 1 хүний цагийг болохоор ингээд арын хаалгатай. Ерөөсөө тэгээд 3 минут нь хөдлөхгүй юм. Зарим дээр нь шууд үсрээд үсрээд л байхгүй болчихож байгаа юм. Ууртай яривал бүр хурдан үсэрчихнэ шүү. Дамдинням гишүүн. Их зөөлөн яривал минут чинь сунана.

Г.Дамдинням: Гишүүддээ оройн мэнд хүргэе. Яах вэ энэ санал шүүмж асуулт энэ тэрээ нэгдсэн чуулган дээр л ярья даа. Зүгээр 2 юм байгаа юм. Байнгын хорооныхоо гишүүдэд хандаад бас даргад хандаад хэлэхэд.

1 дүгээрт бид нар сар гаруйхны өмнө төсвийн тодотгол ярьсан. Төсвийн тодотгол ярьж байхад 2 асуудал гарсан байхгүй юу. Нэг нь юу вэ гэхээр энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргаж өгсөн дүгнэлтийг бүгдээрээ хатуу нарийн ярья гэсэн чинь шинэ засаг байгуулагдлаа хүмүүс нь цалингаа авч чадахгүй боллоо. Яаралтай батлахгүй бол болохгүй чуулган сунах гээд байна гэж 14 хоногийн дотор шахсаар байгаад хүчээр батлуулчихсан байхгүй юу. Тэгэхээр одоо манай Төсвийн байнгын хорооны гишүүд энэ дээр энэ намрын чуулганы 2025 оны төсөв дээр бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг бол нэг бүрчлэн яримаар байна. Болохгүй байгаа юмнуудыг нь бүр яг болгодог болгуулмаар байна. Бид нар тэгэх гэж энд сууж байгаа шүү дээ. Тэгэхэд ч энд сууж байгаа шүү дээ. Шахагдаад баймааргүй байна. Тэгэхээр энэ Заяабал гишүүний гаргаад байгаа энэ санал байна шүү дээ. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг тусад нь хэлэлцдэг байя гэдэг дээр Байнгын хороо өөрсдөө бас бид нар яриад явчихмаар байгаа юм. Тэгэхээр гишүүд маань ч гэсэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргаж байгаа энэ мэдээллүүд дээр нэлээн ажиллаач гэж хэлмээр байгаа юм.

2 дугаар асуудал бол тодотголын үеэр бид нар бас нэлээн асуулт, хариултууд явсан. Тэгээд манай Сангийн яамныхан, Эдийн засаг, хөгжлийн яамныхан, Засгийн энэ яамнууд чинь танд ажил хэргийн шугамаар бичгээр өгүүлчихье гээд таг. Юу ч байхгүй. Өгдөггүй. Төсвийн байнгын хорооны ажлын алба энэ дээрээ бас ажиллаад яамнуудыг бас жаахан шахаад, худлаа яриулаад баймааргүй байгаа байхгүй юу.

Эргэж уулзахгүй нүүр биш ингэж худлаа яриад байж болохгүй шүү дээ. Би бүр тодорхой хэлье. Нийгмийн даатгалын сангийн мөнгийг тэтгэврийн мөнгийг гэсэн үг аваачаад арилжааны банкнуудад өгөөд, алдчихсан. Алдангуутаа нэмээд улам өгчихсөн. Энэ мэдээллийг хэзээ, хэний шийдвэрээр яаж Чингис Хаан банканд, Капитрон банканд, Капитал билүү, Капитал банканд, Үндэсний хөрөнгө оруулалтын банканд энэ банкнууд руу аваачаад хийгээд хаячихсан. Тэгээд нөгөө банкнуудаа дампууруулж чаддаггүй. Нэмээд өгчихсөн байдаг. Тэндээсээ өрийг нь төлчихсөн ч юм шиг нэг ийм завхарсан юмнууд яваад байгаа байхгүй юу. Тэгээд үүний мэдээллийг энэ яамнуудаас, Засгийн газраас бид нарт өгнө. Танд нэн даруй л бичгээр өгнө гэсэн байхгүй. Таг. Тэгэхээр бид нар нэг ийм төөрч байгаа гөлөг шиг байгаад байх албагүй л байх. Улсын Их Хурал, бас Төсвийн байнгын хороо бид нар энэ дээрээ хариуцлагатай хандмаар байгаа байхгүй юу бүгдээрээ. Тэгэхээр энийгээ бид нар авмаар байна. Мэдээллээ авмаар байна. Би бол саяын тэр асуусан асуултаа Нийгмийн даатгалын сангийн өрийг хэдэн оны ямар, ямар шийдвэрээр аль, аль банкнуудад хэдэн удаа яагаад өгчихсөн юм. Энийг энэ төсвийн хэлэлцүүлгээс өмнө авмаар байна. Сангийн яамнаас аваад өгмөөр байна. Манай Төсвийн байнгын хорооны ажлын албанаас. Тэгээд энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг тусад нь сайхан хэлэлцээд, болохгүй байгаа юмнуудыг нь засаж тааруулах ажил бид нарт байгаа шүү дээ. Эрх нь байгаа шүү дээ. Бид нарын үүрэг тэр байхгүй юу. Төсвийн байнгын хорооны. Ажлын хэсгүүд гарна. Тэгэхээр энэ дээрээ ажиллацгаая л гэж хэлэх гэсэн юм.

Ц.Даваасүрэн: Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: өдрийн мэнд оройн мэнд юм уу. Ер нь өмнөх хүмүүсийнхээ хэлсэн саналыг давхцуулаад, бас баталгаажуулаад дэмжээд, хүчтэй

болгоод хэлчихье гэж бодож байна. Заяабал гишүүний хэлсэнчлэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргасан 2 янзын дүгнэлт байгаа. Төсвийн дунд хугацааны хүрээ, тэгээд ирэх оны төсвийн тухай хууль дээр гаргадаг. Маш сайн, хамгийн гол нь маш сайн дүгнэлтүүд гаргаад байгаа. Би өөрөө эдийн засагч Энхбаярыг сайн мэднэ. Энэ зөвлөлд нь байгаа Отгонтуяа багш, Дэлгэрсайхан, математикийн багш Ууганбаяр бүгд маш чадалтай хүмүүс орчихсон байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хүмүүс цаг зав гаргаад, хүч хөдөлмөрөөр зарцуулаад хийчихсэн юмыг нь гишүүд нэг богинохон хугацаанд бараг урд өдөр мэдээлэл нь ирээд байгаа юм уу хаашаа юм заримдаа. Энэ болохоор бүр 2 7 хоногийн өмнө нөгөө гарчихсан байсан юм. Онлайн нөгөө parliament.mn дээр тавьчихсан байсан шүү дээ. Тэгэхэд хэвлэгдээд яг уржигдар уу, хэзээ юэ ирсэн чинь тухайн гишүүний идэвх чармайлтаас юм хамаарчих гээд байна шүү дээ. Тэгэхээр нөгөө аливаа төсвийн хууль тогтоох үйл ажиллагаа чинь маш чанаргүй болчих гээд байгаа нь хайран санагдаад байгаа юм. Гишүүн муудаа биш. Гишүүн заавал мэдэх албагүй. Хурдан унших албагүй. Тэгэхээр эд нарын хийсэн энэ хөдөлмөрийг үнэлээд сайхан уншаад танилцаад хэлэлцдэг байя гэж хүсэж байгаа. Тэгээд би өмнө нь бас хэлж байсан юм. Төсвийн сахилга батыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл байгуулагдсанаар төсвийн сахилга батыг сайжруулж чадах чадах уу гэдэг судалгааг анх байгуулагдахаас нь өмнө хийсэн хүн учраас бас мэдээж дэмжих нь дамжиггүй. Чухлын хэлчихсэн юм. Харин ч энэ байгууллагын, энэ зөвлөлийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, хөрөнгө хүний нөөцөөр хангах ёстой гэдэг бүр саналыг гаргасан хүн байгаа юм. Тэгээд энэ дээр бас ингээд ажлыг нь аваад үзэхээр хүмүүс бол гишүүд маань энд тэндээс өм цөм, өм цөм яриад байгаа юмнуудыг комплекс ингээд оруулчихсан байгаа. Өрийн удирдлагын асуудал байна. Сангуудын асуудал байна. Тэр дотроо Эрүүл мэндийн даатгалын сан маш чухал

л саналууд байна лээ шүү. Тэр макро эдийн засгийн тооцооллууд бол чухал. Зөвхөн 1, 2 тоо ч биш. Сая Эдийн засгийн байнгын хороон дээр бас гишүүд асууж байна лээ. Энэ дээр зүгээр ерөнхийд нь хэлчихье.

Тэгээд бас нэг зүйл Заяабал гишүүний хэлсэн дээр, Ганзориг гишүүний хэлсэн дээр нэмж хэлэхэд Үндэсний аудитын газрын гаргасан дүгнэлт бас чухал байна. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нэмэх нь Үндэсний аудитын газар. Ерөөсөө энэ тусгай биеэ даагаад шүүмж, зөвлөмж, санал гаргадаг, үнэлэлт, дүгнэлт гаргадаг байгууллагууд тайлан гарсан нь үнэн юм бол маш их цаг хугацаа, хөдөлмөр зарсан нь үнэн юм бол тусгайлан авч хэлэлцэх нь зүйтэй гээд ингээд товчхондоо хаачихъя. Олон юм дотор нь байна. Өнөөдөр яриад яах вэ гэж бодож байна. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Гишүүд үг хэлж дууслаа. Тийм зөв. Ер нь манай Их Хурал хувцасгүй, шалдан хүн шиг Их Хурал байхгүй юу. Бусад Их Хурал бол ингээд Их Хурлын дэргэд нь институтууд нь байж байдаг юм. Төсвийн алба нь байж байдаг. Тэр төсвийн алба нь болохоор ингээд макро эдийн засгийн бүх судалгаануудыг нь хийгээд өгчихдөг, туслалцаа үзүүлчихдэг, төсвийн бүх үзүүлэлтүүдийг нь гаргаад өгчихдөг тийм албатай байдаг байхгүй юу. Манайхан байхгүй. Тийм учраас яах вэ, зүгээр Байнгын хорооны гишүүдийгээ болж өгвөл /Чойжоо байж бай/ би энэ чуулганы явцад бас ингээд энэ төсвийн албууд нь хөгжсөн бусад орны Их Хурлын үйл ажиллагаатай би бас танилцуулья гэж бодоод байгаа юм. 2013 онд би Төсвийн шинжилгээний албаны хуулийг нь өргөн барьсан юм. Тэр үед бол гишүүд ерөөсөө тэгээд хүлээж авдаггүй байсан байхгүй юу. Тэгээд тоодоггүй. Одоо харин бас ингээд та нар өөрсдөө анхаараад яриад байгаа нь бол маш зөв. Яагаад гэвэл Их Хурлын гишүүн гэдэг бол мэргэн бөөдий, хувилгаан биш байхгүй

юу. Тийм учраас тэр хүмүүст тусалдаг албад нь байх ёстой. Зүгээр би харин сая Заябал гишүүний хэлж байгаа тэр юун дээр хэдүүлээ Дэгийн тухай хуульд ч юм уу өөрчлөлт оруулаад, эд нар ингээд макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг, төсвийн үзүүлэлтүүдийг ямар нэг хэмжээгээр ийм зөвлөмж гаргаж болно. Тэгэхдээ тэр бол бүр яг үүгээр бай гэсэн үг биш. Тэр нь Их Хурлын гишүүдэд барих чиг баримжаа л болох ёстой байхгүй юу. Яагаад гэвэл төсөв өргөн баригдсанаасаа хойш цэвэр Их Хурлын ажил байдаг. Өөрөөр хэлэх юм бол тэр оруулж ирсэн төсвийг яаж хөдөлгөх вэ гэдэг, яаж батлах вэ гэдэг нь Их Хурлын бүрэн эрх байхгүй юу.

Тийм учраас Их Хурал бүрэн эрхээрээ шийдвэрлэхийн тулд өөрийн гэсэн тоотой байх ёстой шүү дээ. Тэгэхээр би зүгээр одоо хэдхэн хүний гаргаж байгаа, одоогийн энэ макро эдийн засгийн төсөөлөл энэ тэрийг би зүгээр яг баталгаатай гэж бас хэлж чадахгүй байна. Яагаад гэвэл би өөрөө үзээгүй учраас. Ямар загварчлал ашиглаад байна вэ. Тэр хүн, хүчний чадавх нь эд нарт байна уу, үгүй юу гэдгийг би мэдэхгүй байна. Жишээлбэл Солонгосын гэдэг юм уу, Америкийн төсвийн алба нь бүхэл бүтэн 80-100 хүнтэй эрдэмтэд ажиллаж байгаа байхгүй юу даа. Тэнд бүх юм нь бий. Гэтэл манай энэ 8 хүний гаргасан дүгнэлтийг бид нар ингээд аваад явчихад бас болох уу, үгүй юу гэдэг юмнуудаа бас бодох хэрэгтэй. Хэрвээ бид яг тэгж явъя гэж бодож байгаа бол яг тэр утгаар нь манай Их Хурлын дэргэд төсвийн тэр том албыг нь бий болгож өгөх ёстой. Яагаад гэвэл төсөв гэдэг бол Их Хурлын үндсэн ажил. Тийм учраас энэ үндсэн ажлаа хийдэг бүтцээ бий болгохын тулд ажиллах ёстой. Одоо Төсвийн шинжилгээний алба байгуулж өгснийг манай Тамгын газар авчихсан байгаад байхгүй юу. Тэр буруу. Яагаад гэвэл Тамгын газар чинь өөрөө нэг төсвийн ерөнхийлөн захирагч л байхгүй юу. Нэг төсвийн ерөнхийлөн захирагч нөгөө төсвийн ерөнхийлөн захирагчдаа

чиг баримжаа өгч болохгүй. Тийм учраас хэрвээ энэ төсвийн алба байх юм бол хараат бус Төсвийн байнгын хорооныхоо дэргэд байдаг алба байх ёстой болохоос биш яг нэг төсвийн ерөнхийлөн захирагч болчихоод бусад төсвийнхөө ерөнхийлөн захирагч нарыг захирна гэдэг юм уу, тэрний төсвийг хянана гэдэг ойлголт байж болохгүй юм. Тэгэхээр энэ мэтийн асуудлуудыг хэдүүлээ нэг сайн яриад, эдний гаргаж байгаа энэ зөвлөмжүүдийг ер нь бас зөв байх хэлэлцээд хаврын чуулганы эхэнд байдаг юм уу хэлэлцээд Төсвийн хүрээний мэдэгдэл оруулж ирэх гэж байгаа юман дээр та нар бас анхаараарай гээд батлаад өгчхөж болно. Яагаад гэвэл Их Хурал бид нар үүгээр энэ жилийнхээ, ирэх 3 жилийнхээ төсөөллийг баримжаална шүү гээд Их Хурлын гарын авлага бэлдэж өгч байгаа байхгүй юу бид нар.

Яагаад гэвэл Монгол банкны оруулж ирж байгаа мөнгөний бодлогын тоонуудыг бид нар шууд хүлээн зөвшөөрөхгүй байх ёстой. Өөрийн тоотой байх ёстой байхгүй юу. Тэр өөрийн тоог гаргаж өгөх бүтэц нь эд нар болчих гээд байгаа байхгүй юу. Тийм учраас энэ албаа бид нар нэлээн сайн бэхжүүлээд, тэрний дараа бол харин бид нарын барьдаг тоо байх ёстой байхгүй юу. Харьцуулж. Одоо бол манайхан ямар тоо барьж байгаа гэвэл Голден Сакс тэгсэн байна лээ. Дэлхийн баг ингэсэн байна лээ гээд гаднын тоо яриад байгаа байхгүй юу. Биш. Их Хурал өөрийн гэсэн тоотой байх ёстой байхгүй юу. Тийм учраас бид нар энэ өөрийн гэсэн тоогоо бий болгох энэ институцийг бий болгож Их Хурлын гишүүдийнхээ энэ ярьж байгаа саналыг дэмжиж байна. Тийм учраас би энэ ойрын үед бас Сангийн яамтай хамтраад гишүүдээ яг энэ чиглэлээр төсвийн албанд сайн бэхэжсэн Их Хурлын парламентын үйл ажиллагаанууд бас танилцуулна гэж ингэж бодож байна.

Ер нь бол энэ дүгнэлтийг хэлэлцдэг болгохын тулд Дэгийн тухай хуульд

өөрчлөлт оруулах хэрэгтэй болно. Тэгээд хэлэлцээд баталдаг. Тэгээд тэр баталсныгаа бид нар чиг баримжаа болгож явах хэрэгтэй байхгүй юу.

Хууль зүйн дүгнэлттэй холбогдолтой ер нь бол яах вэ та нар чинь өөрсдөө хууль санаачлагч нар шүү дээ. Тийм учраас Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хууль эндээ өөрчлөлт оруулах гэж байгаа бол Их Хурлын гишүүн өөрөө санаачлаад явах бүрэн эрх нь та нарт бий шүү гэж.

Тэр шаардсан мэдээллүүдийг хуучин Байнгын хороо чинь бол 4, 5 хүнтэй байсан юм. Одоо чинь ерөөсөө 2, 3 хүнтэй болгочихсон юм байна лээ. Тийм учраас бас их хэцүү болчихсон. Тэгэхдээ аль болох та нар бас энэ протоколоор Их Хурлын гишүүдийн мэдээлэл шаардаж байгаа асуудлуудыг тэмдэглэж аваад, тэгээд яамнуудаас, холбогдох газруудаас нь гаргаж өгч байя. Мэдээлэл үнэн зөв байх ёстой. Худлаа байх юм бол хуулийн хариуцлага хүлээдэг байх ёстой.

Ингээд Их Хурлын гишүүд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 төсвийн төсөлтэй холбогдуулаад үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Гишүүд ээ, санал хураалтад бэлтгээрэй. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Хуралдаанд 18 гишүүн оролцоноос 13 дэмжиж, 72.2 хувиар хэлэлцэхийг дэмжсэн байна.

Чуулганд танилцуулах гишүүнээр шинэ гишүүнээ томилчихъё. Мөнхсоёл гишүүн танилцуулъя.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн хуульд өөрчлөлт оруулах тухай төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. Төсвийн байнгын хорооны ээлжит хуралдаан дууссаныг мэдэгдье. Баярлалаа гишүүддээ.

17.04 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ